

**Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын допингийн Давж заалдах комисс Н.Өсөхбаярын өргөдөлтэй, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо, Үндэсний их баяр наадмын Бөхийн салбар хороо, Үндэсний их баяр наадмын бөхийн салбар хорооны Үр дүнгийн удирдлагын багт тус тус холбогдох допингийн маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн хураангуй.**

Допингийн эсрэг үндэсний дүрмийн 13 дугаар зүйлийн 13.10.12-т “Монголын Олон улсын болон үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх комиссын шийдвэр нь эцсийнх байх бөгөөд энэ дүрмийн 14.9-д заасны дагуу олон нийтэд мэдээлнэ”, Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Давж заалдах комиссын шийдвэрийн эх хувь, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хураангуй тайлбар эсхүл үр дүнг тодорхойлсон хэвлэлийн мэдээг Давж заалдах комисс олон нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу олон нийтэд мэдээлж байна.

**Шийдвэрийн дугаар:** Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын допингийн Давж заалдах комисс 2026.05.11-ний өдрийн ДЗК-03/31 дугаар шийдвэр (хэсэгчлэн авав)

**Төлөв:** Хүчинтэй

**Санамж:** Энэхүү тойм нь шийдвэрийн эхийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.

Өргөдөл гаргагч үндэсний бөхийн тамирчин Н.Өсөхбаяраас Монголын Үндэсний Допингийн эсрэг байгууллага НҮТББ, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо, Үндэсний их баяр наадмын Бөхийн салбар хороо, Үндэсний их баяр наадмын бөхийн салбар хорооны Үр дүнгийн удирдлагын багт тус тус холбогдуулан 2026 оны 01-р сарын 09-ны өдөр дараах агуулга бүхий өргөдлийн шаардлагыг гаргадаг. Үүнд:

1. "Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага" НҮТББ 2025 оны 07 дугаар сарын 12-ны өдөр Монгол үндэсний бөхийн тамирчин Н.Өсөхбаяраас допингийн шинжилгээнд зориулж дээж цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулахдаа "Шинжилгээ, мөрдөн шалгалтын" олон улсын стандартаас илт гажсан болохыг тогтоолгох,
2. Илт гажсан шинжилгээний хариунд үндэслэн Үр дүнгийн ажиллагаа явуулсан нь дэлхийн допингийн эсрэг дүрмийн зөрчил үүссэн болохыг тогтоолгох, Үндэсний их баяр наадам зохион байгуулах хороо, Үндэсний их баяр наадам зохион байгуулах хорооны Үндэсний бөхийн салбар хороо, Үндэсний бөхийн салбар хорооны үр дүнгийн удирдлагын баг нь Үр дүнгийн удирдлагын ажиллагаа явуулахдаа тамирчны эрхийг зөрчсөн нь Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Үндэсний допингийн эсрэг дүрэм, Үр дүнгийн удирдлагын олон Улсын стандартыг зөрчсөн болохыг тогтоолгох,
3. 8373854 дугаартай шинжилгээний хариу, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн "Хариуцлага тооцох тухай" 10 дугаартай тогтоолын Н.Өсөхбаярт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгуулах,
4. Н.Өсөхбаяр хорлогдсон болохыг тогтоолгох, Н.Өсөхбаярын барилдах эрхийг сэргээлгэх шаардлагыг гаргасан.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас үндсэн хуралдаан эхлэхээс өмнө Н.Өсөхбаяртай “Эвлэрэх” санал илэрхийлсэн бөгөөд Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо, Үндэсний их баяр наадмын Бөхийн салбар хороо, Үндэсний их баяр наадмын бөхийн салбар хорооны Үр дүнгийн удирдлагын багийн төлөөлөгч нар эвлэрэх боломжгүй гэсэн тул үндсэн хуралдааныг үргэлжүүлэв. Бүрэлдэхүүн дараах байдлаар маргаанд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно. Үүнд:

## 1. Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн тухай

Үндэсний бөхийн салбар хороо 2025.07.21-ны өдөр допингийн шинжилгээний зарим сорьцоос Дэлхийн допингийн эсрэг байгууллагын хориглосон жагсаалтад орсон сөрөг аналитик илэрц гарсан тул Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 7 дугаар зүйлийг үндэслэн “Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэх баг”-ийг 01 дүгээр тогтоолоор байгуулж, гишүүдээр нь Үндэсний бөхийн салбар хорооны гишүүн Д.Давааням, Үндэсний бөхийн салбар хорооны гишүүн Н.Жамъянхүү, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын Гадаад харилцааны албаны дарга С.Зүчи нарын Бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн талаар дараах Дэлхийн допингийн эсрэг дүрэм, түүний дагалдах Олон улсын стандарт болон Допингийн эсрэг үндэсний дүрэмд тусгасан байна. Үүнд:

1. Дэлхийн допингийн эсрэг дүрмийн **7.1-т** “Үр дүнгийн менежментийн Үүргийг Гүйцэтгэх 6.6, 6.8, 7.1.3–7.1.5-р заалтуудад өөрөөр заагаагүй бол Үр дүнгийн менежментийг Дээж авах санаачилга гарах, цуглуулах эрхтэй Допингийн Эсрэг Байгууллагын норм, дүрмээр зохицуулагдана. Үр дүнгийн менежментийг ямар байгууллага зохицуулж байгаагаас хамаарч 8, 13 мөн энэ зүйл, Үр дүнгийн менежментийн Олон улсын стандарт болон Допингийн эсрэг байгууллага тус бүрийн дүрмийн дагуу Үр дүнгийн менежментийн зарчмыг ямар нэгэн үндэслэл бүхий өөрчлөлтгүйгээр 23.2.2-р заалтад тодорхойлсны дагуу албан ёсоор бүртгүүлэн, хэрэгжүүлнэ” гэж заажээ.

2. Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартын **7.1-т** “Үр дүнгийн удирдлагын ажиллагааны эрх бүхий байгууллага нь тамирчин, эсвэл бусад этгээдийн тайлбарыг хүлээн авсны дараа, эсвэл тайлбар өгөх тогтоосон хугацаа дууссаны дараа тамирчин, эсвэл бусад этгээд допингийн эсрэг дүрмийг зөрчсөн гэдэгт итгэлтэй болсон бол тамирчин, эсвэл бусад этгээдэд допингийн эсрэг дүрмийг зөрчсөн гэж үзэж буй тухай нэн даруй мэдэгдэнэ” гэж заажээ.

3. Допингийн эсрэг үндэсний дүрмийн **7.6-т** “Энэ дүрмийн 7.2-т заасан үр дүнгийн удирдлагын ажиллагааг хариуцах эрх бүхий байгууллага нь дүрмийн аливаа зөрчлийг нягтлах, мэдэгдэх үйл ажиллагааг “Үр дүнгийн удирдлагын олон улсын стандарт”-ын дагуу зохион байгуулна” гэж заажээ. Дээрх зохицуулалтаас үзвэл Үр дүнгийн удирдлагын ажиллагааг “Эрх бүхий байгууллага” хариуцахаар заажээ.

Үр дүнгийн удирдлагын ажиллагааг хэрэгжүүлэгч нь Үндэсний их баяр наадмыг Зохион байгуулах хороо нь Томоохон үйл ажиллагааг зохион байгуулагч гэсэн тайлбаруудыг өгдөг. Тэгвэл Дэлхийн допингийн эсрэг дүрмийн **Хавсралт1** тодорхойлолтууд хэсэгт “Томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид” Тивийн бүс нутгийн болон бусад Олон улсын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй үндэсний олимпын хороодыг багтаасан Тивийн холбоод болон бусад Олон улсын байгууллагууд” гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолтоос үзвэл Томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид Үндэсний их баяр наадмыг Зохион байгуулах хороо нь орохооргүй байна.

Допингийн эсрэг үндэсний дүрмийн **8-д** Үр дүнгийн удирдлага, шударгаар хянан шийдвэрлүүлэх болон хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэрийг мэдэгдэх хэсэгт **8.2-т** “Зөвхөн Үндэсний их баяр наадмын хувьд Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан эрх бүхий этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, шийдвэр гаргана” гэж заасан

боловч “Эрх бүхий этгээд” гэх ойлголтод ямар байгууллага орох талаар илүү нарийвчлан зохицуулалтыг Допингийн эсрэг үндэсний дүрэм тусгаагүй байна.

Харин 2025 оны 1 дүгээр сараас үйлчилж эхэлсэн Биеийн тамир, спортын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т “Допингийн эсрэг үндэсний байгууллага энэ хуулийн 27.3-т заасан зарчмын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ хэсэгт 28.3.6-д “үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, шийтгэл ногдуулах” гэж заажээ. Мөн Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагаас 2026.05.11-ны өдөр ирүүлсэн бичгэн тайлбарт “... Үндэсний их баяр наадмын тухай хууль болон Допингийн эсрэг үндэсний дүрэмд шууд заагаагүй “үр дүнгийн удирдлагын баг” гэх бүтэц байгуулсан, уг бүтцээр олонхын саналаар шийдвэр гаргасан... Иймээс тухайн эрх хасах шийдвэр нь хууль болон дүрэмд заасан эрх бүхий бүтэц, эрх хэмжээ, журмын хүрээнд гарсан эсэх нь тодруулах шаардлагатай асуудал гэж МҮДЭБ үзэж байна” гэж ирүүлснээс нэгтгэн үзвэл илүү нарийвчилсан зохицуулсан Биеийн тамир, спортын тухай хуулиар Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага нь Монголын Үндэсний Допингийн Эсрэг байгууллага байна гэж үзлээ.

Харин “Үр дүнгийн удирдлагын баг”-ын хэрэгжүүлсэн гэх үр дүнгийн удирдлагын ажиллагаа нь Үр дүнгийн удирдлагыг Биеийн тамир, спортын тухай хууль, Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Үр дүнгийн Олон улсын стандарт, Допингийн эсрэг үндэсний дүрэмд заасан “эрх бүхий байгууллага” гэсэн ойлголтод хамаарахгүй байна.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нь үр дүнгийн удирдлагын хэрэгжүүлэгчийн талаар эрх бүхий бүтэц, хэмжээнд эргэлзээ үүссэн бол Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 7.1.1-т “Аль нэг Допингийн Эсрэг Байгууллагыг Үр Дүнгийн Менежментийн хариуцлага хүлээлгэх тухай Допингийн Эсрэг Байгууллагуудын хооронд маргаан гарсан тохиолдолд, Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг тухайн хариуцлагыг аль байгууллагад ноогдуулахаа шийдвэрлэнэ” гэж заасны дагуу Дэлхийн допингийн эсрэг агентлагт хандаж шийдвэрлүүлэх, зөвлөмж, аргачлалыг тухайн цаг үед нь авах боломжтой байсан байна гэж үзлээ.

## **2. Үр дүнгийн удирдлага хэрэгжүүлэгчийн бүрэлдэхүүн**

Үр дүнгийн удирдлагын хэрэгжүүлэгчийн бүрэлдэхүүн нь Допингийн эсрэг үндэсний дүрмийн 8.4-т “Үндэсний допингийн эсрэг байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүд, тус байгууллагын ажилтан, бусад комиссын гишүүд, зөвлөх, түүний харьяалах байгууллага болон мөрдөн шалгалт хийхэд оролцсон ажилтнууд, холбогдох маргаанд оролцсон, аливаа шийдвэрийн төслийг бэлтгэх үүрэгтэй албан хаагчдыг хэрэг хянан шийдвэрлэх комиссын гишүүнээр томилохыг хориглоно” гэж заасан шаардлагад нийцүүлэн байгуулахаар заасан байна. Үндэсний их баяр наадмын бөхийн салбар хорооны гишүүн Д.Давааням, Үндэсний их баяр наадмын бөхийн салбар хорооны гишүүн Н.Жамьянхүү нар нь Үр дүнгийн удирдлагын Бүрэлдэхүүнд ажилласан, мөн Үндэсний их баяр наадмын бөхийн салбар хорооны гишүүдийн хувиар давхар ажилласан, С.Зүчи нь Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын ажилтны хувьд оролцсон зэрэг нь дүрмийн шаардлагад нийцээгүй байна. Допингийн эсрэг үндэсний дүрмийн 8.5-д заасан хараат бус байх, допингийн эсрэг үйл ажиллагааны чиглэлээр хууль, спорт, анагаах ухааны болон шинжлэх ухааны бусад салбар дахь ажлын туршлагыг нь харгалзан бүрэлдэхүүнийг томилохоор зохицуулсан байна.

Мөн Допингийн эсрэг үндэсний дүрэмд **Үйл ажиллагааны хараат бус байдал** тайлбарт Мөрдөн шалгах ажиллагаа болон хэргийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед бүх допингийн эсрэг байгууллагын удирдах зөвлөлийн гишүүд, ажилтнууд, комиссын гишүүд, зөвлөхүүд болон үр дүнгийн менежментийг хариуцдаг албан тушаалтнууд, эсхүл түүний харьяа байгууллагуудын албан тушаалтнууд зэрэг хамаарал бүхий этгээд нь допингийн эсрэг байгууллагын сонсголын хэсгийн гишүүн, эсхүл нарийн бичгийн даргаар томилогдохыг хориглох, өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах зарчмыг хэлнэ” гэж зааснаар Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын ажилтан үр дүнгийн удирдлагын бүрэлдэхүүнд оролцохыг хориглосон байна.

### **3. Эхний хянан үзлэг стандартын дагуу хийгдсэн эсэх**

Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 7-д заасны дагуу “Энэ Дүрмийн (7, 8, 13-р зүйлд заасан) Үр дүнгийн менежмент нь допингийн эсрэг дүрмийн зөрчлийг шударга, түргэн шуурхай, үр дүнтэй гаргах зохицуулалтын процесс юм. Үр дүнгийн менежментийн ажиллагааг явуулдаг Допингийн Эсрэг Байгууллага бүр дараах зарчмуудад нийцүүлэн Допингийн эсрэг дүрмийн бодит зөрчлийн тухай урьдчилан хянан хэлэлцэх ажиллагаа явуулна. Допингийн Эсрэг Байгууллага бүр өөрийн Үр Дүнгийн Менежментийн ажиллагааг явуулах, хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд Допингийн Эсрэг Байгууллагын Үр Дүнгийн Менежмент нь Үр Дүнгийн Менежментийн Олон Улсын Стандартад тодорхойлсон шаардлагуудыг хамгийн доод хэмжээнээс эхлэн хангасан байна”, Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартын 7.1 дэх заалт, Допингийн эсрэг үндэсний дүрмийн 7.1-т “Үр дүнгийн удирдлага нь дүрмийн зөрчлийн асуудлыг шударга, шуурхай болон үр дүнтэй аргаар шийдвэрлэхэд зориулсан үйл ажиллагаа юм” гэж тус тус зохицуулснаас үзвэл “Допингийн эсрэг дүрмийн бодит зөрчлийн тухай урьдчилан хянан хэлэлцэх ажиллагаа явуулах” процессыг зааж өгчээ.

Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартын 5-д зааснаар “Үр дүнгийн удирдлагын эхний үе шат үе шатанд хамаарах үйл явцыг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд: Сөрөг аналитик илэрц (5.1 зүйл), гаж илэрц (5.2 зүйл) болон нийцлийн боломжит алдаа (5.3.1.1), байршлын мэдээллийн алдаа зэрэг (5.3.1.2 зүйл) бусад асуудлууд (5.3 зүйл) болон тамирчны биологийн паспортын илэрц (5.3.1.3 зүйл). Энэхүү стандартын 5.3 зүйлд хамаарах асуудлаар мэдэгдэх шаардлагыг 5.3.2 зүйлд тусгасан болно” гэж заасан бөгөөд Үр дүнгийн ажиллагааны эрх бүхий байгууллага сөрөг аналитик илэрцийг хүлээн авсны дараа, дараах зүйлийг тодорхойлох зорилгоор хянан үзлэг хийхээр зохицуулсан. Тухайлбал;

- а.** “Эмчилгээний зорилгоор чөлөөлөх” олон улсын стандартад заасны дагуу холбогдох эмчилгээний зорилгоор чөлөөлөх батламжийг олгосон, эсвэл олгох гэж буй эсэх
- б.** Сөрөг аналитик илэрцийн шалтгаан нь “Шинжилгээ, мөрдөн шалгалтын” олон улсын стандарт, “Лабораторийн” олон улсын стандартаас илэрхий гажсан байдалтай холбоотой эсэх
- в.** Сөрөг аналитик илэрц нь зөвшөөрөгдсөн замаар хориглосон бодисыг залгисантай холбоотой болох нь тодорхой байгаа эсэх гэснийг эхний хянан үзлэгээр тодорхой болгохоор заажээ. Дээрх а, б, в-д зааснаар тамирчинд сөрөг аналитик илэрц илэрсний дараа хянан үзлэгээр заавал хийхээр зохицуулсан.

Тамирчин уг процессыг стандартын дагуу яваагүй гэж маргаж байгаа тохиолдолд холбогдох дүрэм, стандартын дагуу явуулсан гэдгээ шинжилгээ цуглуулсан байгууллага буюу Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ заавал буюу зайлшгүй нотлох үүргийг хүлээнэ. Уг үүргийг дараах дүрэм, стандартаар хүлээлгэсэн байдаг.

- Дэлхийн допингийн эсрэг дүрэм **3.2.3-д** “... Хэрэв тамирчин болон бусад этгээд нь сөрөг аналитик илэрц, эсвэл байршлын тухай мэдээллийн алдаатай холбоотойгоор бий болсон допингийн эсрэг дүрмийн зөрчлийн талаар дор дурдсан үндэслэлийг бусад олон улсын стандартад үндэслэн гаргаж тавьсан тохиолдолд допингийн эсрэг байгууллага тухайн үндэслэл нь сөрөг аналитик илэрц болон байршлын мэдээллийн алдаа үүссэн шалтгаан болохгүй гэдгийг **зайлшгүй нотлох шаардлагатай**”  
а. Допингийн эсрэг байгууллага нь “Шинжилгээ, мөрдөн шалгалтын” олон улсын стандартын дээж цуглуулах, тээвэрлэхтэй холбоотой тухайн заалтууд нь сөрөг аналитик илэрцээс шалтгаалсан допингийн эсрэг дүрмийн зөрчлийг бий болгосон **боломжит шалтгаан биш гэдгийг нотлох шаардлагатай**.
- Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **8.3.1-д** “Дээж цуглуулах байгууллага нь авсан бүх дээжийг Допингийн хяналтын байрнаас тээвэрлэхээс өмнөх хадгалах, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хамгаалах шалгуурыг тогтооно. Эдгээр шалгуурууд нь хамгийн багадаа дээж хадгалагдаж буй байршлыг нарийвчлан тогтоох, дээжийг хадгалах, баримтжуулах, хагадлалтын хуудас хөтлөх ёстой”
- Допингийн эсрэг үндэсний дүрмийн **3.5-т** Хэрэв тамирчин болон бусад этгээд нь сөрөг аналитик илэрц, эсхүл байршлын тухай мэдээллийн алдаатай холбоотойгоор бий болсон дүрмийн зөрчлийн талаар дор дурдсан үндэслэлийг бусад олон улсын стандартад үндэслэн гаргаж тавьсан тохиолдолд Үндэсний допингийн эсрэг байгууллага тухайн үндэслэл нь сөрөг аналитик илэрц болон байршлын мэдээллийн алдаа үүссэн шалтгаан болохгүй гэдгийг **зайлшгүй нотлох шаардлагатай**:
- Допингийн эсрэг үндэсний дүрмийн **3.3.7-д** “хэрэв тамирчин холбогдох олон улсын стандарт заасан үндэслэлийн дагуу тухайн таамаглалыг няцаасан тохиолдолд Үндэсний допингийн эсрэг байгууллага тухай үндэслэлүүд нь **сөрөг аналитик илэрцэд хамаарахгүй гэдгийг нотлоно**” гэж заасан.

Тамирчин нотлогдохгүй байгаа тул нотлохыг шаардаж байгаа нь стандартын дагуу бөгөөд заавал нотлох үүрэг нь Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагад шилжих юм. Иймээс дээж цуглуулах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа нь стандартын дагуу явагдсан эсэхийг тогтоох, үнэлэх, дүгнэх зайлшгүй шаардлага үүснэ.

### **3.1. Дээж цуглуулах ажиллагаа стандартын дагуу явагдсан эсэх**

Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартад “дээж цуглуулах үйл ажиллагаа гэдэг нь тамирчинд мэдэгдэл өгөхөөс эхлэн тамирчин допингийн хяналтын байрыг орхих хүртэл хийгдсэн бүх үйл ажиллагаа” гэж тодорхойлжээ.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын Допингийн хяналтын ажилтан Д.Энхсанаа нь 2025 оны 07 дугаар сарын 12-ны өдрийн орой Н.Өсөхбаярын шээсний дээжийг 8373854 дугаартай А, В сорьцын саванд авсан гэж, -18 градус гэж бичиж Допингийн хяналтын хуудас (Doping control form)-ыг бөглөсөн байна.

Д.Энхсанаа нь Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **7.4.4-д** “Допингийн хяналтын ажилтан нь дээж цуглуулах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулсан талаарх аливаа санал хүсэлтийг асууж, баримтжуулах боломжийг тамирчинд олгоно”, **7.4.7-д** “Допингийн хяналтын ажилтан нь гарын үсэг зурсан, дээж цуглуулах ажиллагааг тэмдэглэсэн хуудасны хуулбарыг тамирчинд өгнө” гэж заажээ.

Хадгалалт, тээвэрлэлтийн хуудас (Chain of custody form)-д Д.Энхсанаа 2025.7.12-ны оройн 23 цаг 15 минутад бөглөж, Номинцэцэг 23 цаг 15 минутад бөглөж, С.Зүчи 2025.7.13-ны оройн 18 цаг 45 минут гэж бөглөсөн байна.

Д.Энхсанаа нь шинжилгээнүүдийн сорьцын дугаарыг тэр хуудасны дугаартай бүгдийг нь камер доор шалгасан, нөгөө хөндлөнгийн хяналтууд л холоос л харна уу гэхээс яг тэр хуудсыг бол барихгүй, дээж авах үеийн допингийн хяналтын байрны 2 буланд камер байдаг шинжилгээний процедурыг хянах зорилгоор, шинжилгээнүүдийг сорьцын дугаарыг тэр хуудасны дугаартай бүгдийг нь камер доор шалгадаг, камерын бичлэгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалагддаг гэж гэрчээр мэдүүлдэг. Мөн Д.Энхсанаагийн тайланд камерын хяналтын доор хөндлөнгийн бүрэлдэхүүн байсан гэж бичсэн бөгөөд С.Зүчи “дээж авах үеийн бичлэг манай дээр байгаа” гэж мэдүүлдэг.

Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **7.4.1-ийн а.** Хавсралт С-д Шээсний дээж цуглуулах **С.3.1-д** “Допингийн хяналтын ажилтан нь дээж бүр зохих ёсоор авагдсан, эх үүсвэр нь мэдэгдсэн болон битүүмжлэгдсэн байх нөхцөлийг хангана”, **С.3.2-т** “Допингийн хяналтын ажилтан, эсвэл хянагч нь шээсний дээж өгөх ажиллагааг биечлэн гэрчлэх үүрэгтэй” гэсний дагуу дээж авах үеийн баримтыг шаардах нь 8373854 дугаартай А, В сорьцын савны код, допингийн хяналтын хуудастай тохирсон эсэх, сав баглаа, битүүмжлэл алдагдаагүй байсан эсэх, бохирдоогүй байсан эсэх, тамирчны дээж 8373854 дугаартай А, В ижил сорьцын саванд маргаангүй орсон эсэхийг тогтоох зорилготой байдаг.

Дээж цуглуулах үед хуулийн байгууллагуудын төлөөллүүд хяналт тавьж ажилласан байх боловч зөвхөн “Сорьцын савны дугаарлалт бүхий хуудас”-д гарын үсэг зурсан байгаа болохыг дурдаж байна.

Д.Энхсанаагийн бичсэн тайланд “...ХБНГУлсын Дрезденийн Спортын биохими ба Допингийн анализын Шинжлэх Ухаан, технологийн институтид биечлэн хүргэж өгөх гэрээт ажлыг зохион байгууллан ажиллалаа” гэж бичсэн нь сорьцууд яваагүй байхад хүргэж өгсөн мэтээр нөхөж бичсэн байж болзошгүй, хэн хүлээн авсан, хэрхэн баталгаажуулсан эсэх нь тодорхойгүй, хөндлөнгийн хяналт тавьсан байгууллагуудын төлөөлөл Д.Энхсанаагийн тайланд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байгааг дурдаж байна.

Дээж цуглуулах үеийн камерын бичлэг, холбогдох мэдээллийг авах талаар удаа дараа Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-д хандсан, шаардсан боловч гаргаж өгөөгүй, нотлоогүй тул Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ийг нотолж чадаагүй гэж Бүрэлдэхүүн дүгнэлээ.

### **3.2. Дээж хадаглалт стандартын дагуу явагдсан эсэх.**

Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **8.3.1**-т “Дээж цуглуулах байгууллага нь авсан бүх дээжийг допингийн хяналтын байрнаас тээвэрлэхээс өмнө хадгалах, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг нь хамгаалах шалгуурыг тогтооно. Эдгээр шалгуурууд нь хамгийн багадаа дээж хадгалагдаж буй байршлыг нарийвчлан тогтоох, дээжийг хадгалах, баримтжуулах, хадгалалтын хуудсыг хөтлөх ёстой. Допингийн хяналтын ажилтан дээж эдгээр шаардлагыг хангасан орчинд хадгалагдах нөхцөлийг бүрдүүлнэ”, **8.3.2**-т “Дээж цуглуулах байгууллага нь дээж тус бүрээр баримтжуулж дууссан эсэх, найдвартай боловсруулсан эсэхийг баталгаажуулах зорилгоор дээжийг хадгалах сүлжээ, дээж цуглуулах баримт бичгийг бүртгэх системийг боловсруулна. Үүнд сорьц ба дээж цуглуулах бичиг баримтын аль аль нь товлосон газраа ирснийг баталгаажуулах ажиллагааг багтаана” гэж тус тус заажээ.

Д.Энхсанаагийн бичсэн тайланд “... 23 цаг 35 миунтад Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын ажилчид, хяналтын бүрэлдэхүүний хамт Төв цэнгэлдэх хүрээлэнгийн допингийн хяналтын байрнаас гарч 23 цаг 35 миунтад Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын 201 тоот өрөөнд байрлах хөлдөөгчинд, лацтай цүнхний хамт хийж хөлдөөчөө лацадсан” гэж бичсэн байдаг.

Харин стандартаар Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нь хамгийн багадаа дээжийг хадгалах, баримтжуулах, хадгалалтын хуудсыг хөтлөх, дээж тус бүрээр баримтжуулах, дээж цуглуулах бичиг баримтын аль аль нь товлосон газраа буюу Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын байранд ирснийг баталгаажуулах ажиллагаанууд хийх ёстой байсан боловч уг ажиллагааг хийсэн эсэх нь тодорхойгүй, уг баталгаажуулалт хийсэн нотолгоог Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ гаргаж өгөөгүй тул нотолж чадаагүй гэж Бүрэлдэхүүн дүгнэлээ.

### **3.3. Тээвэрлэлт стандартын дагуу явагдсан эсэх.**

Допингийн шинжилгээг биечлэн хүргэлтээр Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын ажилтан С.Зүчи хүргэсэн талаар Chain of custody хуудас-д 2025.7.13-ны оройн 18 цаг 45 минут хүлээлгэн өгсөн гэж өөрийнхөө мэдүүлгээр тайлбарладаг. Харин 2024 оноос өмнөх нь баталгаат шуудан буюу DHL-ээр явагддаг байсан. С.Зүчийг тээвэрлэлтийн ямар эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэх, дээж хэзээ өөрийнх нь эзэмшилд очсон эсэх, лабораторид хэрхэн, яаж биечлэн хүргэж, хүлээн авсан өгсөн эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа болно.

Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **9.3.1**-т “Дээж цуглуулах байгууллага нь дээж болон баримт бичгийг бүрэн бүтэн, аюулгүй байдлыг нь алдагдуулахгүйгээр тээвэрлэх системийг бий болгоно”, **9.3.2**-д “Дээж цуглуулах ажиллагаа дууссаны дараа битүүмжилсэн дээжийг дээж цуглуулах байгууллагын зөвшөөрсөн тээврийн хэрэгслээр аль болох хурдан хугацаанд лаборатори руу тээвэрлэх шаардлагатай. Дээж нь цаг хугацаа хоцрох, температурын хэт хэлбэлзэл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан муудах, гэмтэх боломжтой” гэж заасан байдаг.

С.Зүчийн мэдүүлснээр дээж тээвэрлэлтэд “... цагдаагийн 1, тагнуулын 1 ажилтан биечлэн хяналт тавьж дагалдаж явсан, цагдаа, тагнуулаас 24 цагийн хяналт тавьдаг” гэсэн.

Эдгээрийг тогтоох зорилгоор Давж заалдах комиссоос 2026.02.23-ны өдөр ДЗКомиссын ДЗК 01/83 тоотод албан бичиг, 2026.03.12-ны өдөр ДЗКомиссын ДЗК 01/93 тоотод албан бичиг, 2026.04.16-ны өдөр ДЗКомиссын ДЗК 01/113 тоотод албан бичиг, 2026.04.28-ны өдөр ДЗКомиссын ДЗК 01/126 тоотод албан бичгүүдээр тээвэрлэлтийн үетэй холбоотой тайлан, бичлэг, холбогдох бүхий л баримтыг гаргаж өгөхийг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас хүсэж, шаардсан боловч гаргаж өгөөгүйг Бүрэлдэхүүн дурдаж байна.

Мөн тээвэрлэлтэд биечлэн хяналт тавьсан байгууллага болох Тагнуулын Ерөнхий газраас биечлэн хяналтын тайланг хүсэхэд 2026.04.23-ны өдрийн албан бичгээр тээвэрлэлтийн үед хөндлөнгийн хяналтаар биечлэн хүргэлтэд оролцсон, дээж цуглуулах болон тээвэрлэхтэй холбоотой мэдээлэл Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагад байх тул гаргаж өгөх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанаас мөн адил биечлэн хяналтын тайланг хүсэхэд 2026.04.22-ны өдрийн албан бичгээр холбоотой тайлан, бичиг баримт байхгүй, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас гаргуулан авна уу гэж хариу ирүүлсэн.

Бүрэлдэхүүн дээж тээвэрлэсэн Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ болон хөндлөнгийн хяналт тавьсан хуулийн байгууллагуудаас холбогдох баримт, мэдээллийг авахыг хүссэн боловч үр дүнд хүрээгүй болохыг онцлон тэмдэглэж байна.

Үндэсийн бөхийн салбар хороо болон Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-тай 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр “допингийн сорьц тээвэрлэлтэд биечлэн хяналт тавих ажилтны оролцуулах гэрээ”-г байгуулж төсвийг нь гаргасан байх тул гэрээний дагуу тайланг авсан эсэхийг тодруулахад тайлан авах гэрээний заалт байхгүй талаарх тайлбарыг гаргасан болно.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Билгүүн үндсэн хуралдаанд “тээвэрлэлтийн үеийн тайланг манай байгууллагын удирдлага гарган өгөх боломжгүй гэсэн... тээвэрлэлтийн үе тайлан гаргаагүй нь буруу” гэсэн тайлбаруудыг гаргаснаар уг тээвэрлэлт нь стандартын дагуу явагдсан эсэхийг нотлох боломжгүй болгосон.

Мөн С.Зүчийн мэдүүлгээс үзвэл хадгалалтын 8 цаг гаруй, тээвэрлэлтийн 19 цагийн хугацаанд тус тус Хадгалалт, тээвэрлэлтийн хуудас (Chain of Custody) тасарсан байна. Яг тэр хугацаанд дээж хаана, хэний хяналтад байсан бэ? гэдэг асуултад Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ баримтаар хариулах ёстой юм. Chain of Custody “тасраагүй” гэдгийг зөвхөн амаар хэлснээр нотлогдохгүй бөгөөд тасралтгүй байдлын тайлан, баримтжуулалт, бүртгэл байхгүй байгаа нь нотлох баримтын тасалдал гэж Бүрэлдэхүүн үзлээ.

Chain of Custody тасраагүй гэдгийг нотлох нь тухайн дээжийг авснаас лабораторид хүрч шинжилгээ дуусах хүртэлх бүх шатанд хамааралтай ойлголт юм. Тухайлбал дээж солигдоогүй, бохирдоогүй, битүүмжлэл алдагдаагүй, хөндлөнгийн нөлөөнд ороогүй, дээжийг хөргөх эсхүл хөлдөөгч тээвэрлэлтэд температурын өөрчлөлтөд оролгүйгээр тээвэрлэсэн эсэх, муудаагүй эсэхийг тогтоох чухал ач холбогдолтой байдаг. Мөн тээвэрлэсэн болохоо тухайн үеийн холбогдох бусад баримт бичгүүд болох онгоцны тийз, гар болон тээшний бүртгэл, зочид буудлын баримт, унаа хоолны зардлын баримт, визний хураамж зэрэг баримтаар нотлогдох ёстой.

Дээжийн хөдөлгөөний бүртгэл тасарсан, албан ёсны тээвэрлэлтийн тайлан байхгүй, бие даасан болон хөндлөнгийн хяналт тодорхойгүй, сорьцын тасралтгүй хяналт баталгаажаагүй мөн цаашлаад бодитоор тээвэрлэсэн эсэхэд хүртэл эргэлзээ үүсгэхийн зэрэгцээ лаборатори хэзээ хүлээн авсан цаг хугацаатай бүртгэл баримт байхгүй байгааг тул

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нотолж чадаагүй гэж Бүрэлдэхүүн үзэв.

Эхний хянан үзлэгээр “Эмчилгээний зорилгоор чөлөөлөх” олон улсын стандартад заасны дагуу холбогдох эмчилгээний зорилгоор чөлөөлөх батламжийг олгосон, эсвэл олгох гэж буй эсэх, сөрөг аналитик илэрц нь зөвшөөрөгдсөн замаар хориглосон бодисыг залгисантай холбоотой болох нь тодорхой байгаа эсэхийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай болно.

Үр дүнгийн удирдлагын баг нь 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдөр Н.Өсөхбаярын 8373854 дугаартай А сорьцоос сөрөг аналитик илэрц илэрсэн тухай Допингийн эсрэг дүрмийн дагуух мэдэгдлийн 2.3-т зааснаар анхан шатны хянан үзлэгийг хийж 2.3.1 (ЭЗЧ), 2.3.2 (Шинжилгээний хариу Шинжилгээ болон шалгалтын олон улсын стандарт, Лабораторийн олон улсын стандартаас илт гажсан зүйл байхгүй) гэж бичжээ. Харин 3 дах хянан үзлэгийн хэсэг болох Сөрөг аналитик илэрц нь зөвшөөрөгдсөн замаар хориглосон бодисыг залгисантай холбоотой болох хянан үзлэг хийгдээгүй, энэ тухай мэдэгдэлд байхгүй байна.

Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартын **5.1.1.2** “Шинжилгээ, мөрдөн шалгалтын” олон улсын стандарт, эсвэл “Лабораторийн” олон улсын стандартаас илэрхий гажсан эсэхийг Үр дүнгийн удирдлагын ажиллагааны эрх бүхий байгууллага нь сөрөг аналитик илэрцийг хянан үзэхдээ “Шинжилгээ, мөрдөн шалгалтын” олон улсын стандарт, эсвэл “Лабораторийн” олон улсын стандартаас илт гажсан зүйл байгаа эсэхийг тодруулах шаардлагатай” гэж заажээ.

Н.Жамьянхүүгээс “Бид нар бүүр өөрсдөө сая тухайн 07 сарын 23-ны өдөр нөгөө анхан шатны хянан үзлэг хийсэн талаарх бичлэгээ болбол үзлээ, гүйлгэж. Тэрэн дээр болбол бид гурав гурвуулаа байсан. За УБЕГ-т байсан ХЗДХЯ-нд одоо дугтуйтай задалж байгаа бичлэгээ бас нэлээн үзлээ. Энэ дээр болбол яах аргагүй бид нар тодорхой хянан үзлэгүүдийг болбол миний түрүүний хэлсэн хянан үзлэгүүдийг хийсэн байгаад байгаа юм. За ингээд 5.1.1.1-д заасан арга хэмжээнүүд буюу мэдэгдлийг болбол бид нар гомдол гаргагчид болбол и-мэйлээр болон гардуулж болбол өгсөн байгаа. За ингэхээрээ болбол энэ гомдол гаргагч талаас бид нарыг хууль зөрчсөн, код зөрчиж буруу ирүүлсэн гэдэг энэ асуудал болбол ингээд мэдэгдлийг хүргүүлсэн, эрхийг танилцуулсан за мөн тайлбарыг авсан байдаг 07 сарын 25-ны өдөр, за 08 сарын 04-ний өдөр ч гэсэн 08 сарын 06-ны өдөр бас уулзалт хийсэн, за уулзалтын тэмдэглэл бол мөн байгаа” гэж тайлбарыг гаргадаг.

Эхний хянан үзлэг бодитоор хийгдсэн эсэх, хэрхэн яаж баримтжуулсан эсэх нь нотлогдохгүй, баримт болон холбогдох бусад баримтыг хэрэгт гарган өгөөгүй болохыг дурдаж байна.

Харин С.Зүчи гэрчээр мэдүүлэхдээ “5.1.1-ийг хийгээгүй, ADAMS-ийн эрх надад байдаг, гажуудал байсан уу тэгэхээр би өөрөө мэдэж байсан учир шаардлагагүй, тэр үед хийгээгүй” гэж мэдүүлсэн.

Эдгээрээс нэгтгэн дүгнэвэл Үр дүнгийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ эхний хянан үзлэгээр дээж цуглуулах, тэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартаас илт гажаагүй явуулсан гэдэг нь нотлогдоогүй, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нь Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартаас илт гажаагүй явуулсан болохоо нотолж чадаагүй гэж Бүрэлдэхүүн дүгнэв.

#### 4. ADAMS-ийн зөрчлийн тухайд

Дэлхийн допингийн эсрэг дүрмийн **Хавсралт 01** тодорхойлолтууд хэсэгт “ADAMS буюу Допингийн эсрэг удирдлага менежментийн систем гэдэг нь өгөгдөл хадгалах дүрэм, дүрмийн дагуу допингийн эсрэг үйл ажиллагаа явуулахад хөрөнгө оруулагч болон ДДЭА-д туслах зориулалттай өгөгдөл оруулах, хадгалах, хуваарилах болон тайлагнахад зориулсан веб-д суурилсан өгөгдлийн менежментийн хэрэгсэл” гэж тодорхойлжээ.

Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандарт **4.8.6.4-д** “Шинжилгээний бүртгэлийн сан хөтөлдөг олон улсын холбоо, эсвэл допингийн эсрэг үндэсний байгууллага нь дараах нөхцөлийг хангах зорилгоор допингийн эсрэг захиргаа удирдлагын систем /ADAMS/-ийг ашиглана”, **4.9.1.6-д** “Цуглуулсан бүх дээжийн допингийн хяналтын хуудсыг тухайн дээж цуглуулсанд өдрөөс 21 (хорин нэг) хоногийн дотор допингийн эсрэг захиргаа удирдлагын систем /ADAMS/-т бүртгүүлнэ”, **6.3.4-д** “Дээж цуглуулах байгууллага нь хамгийн багадаа дараах шаардлагыг хангасан дээж цуглуулах багажийг л шээс, цусны сорьц цуглуулахад ашиглана. Үүнд: а.Дээжийг битүүмжлэхэд хэрэглэгддэг бүх шилэн сав, сав, гуурс, бусад зүйлүүд нь дугаарлалтын тоон онцгой системтэй байх ба дээж цуглуулах саван дээр допингийн эсрэг захиргаа удирдлагын систем /ADAMS/-ийн шаардлагад нийцсэн баркод эсвэл түүнтэй төстэй өгөгдлийн кодтой байх”, Лабораторийн Олон улсын стандартын **5.3.8.4-д** “Лаборатори гарын үсэг зурагчид, эсхүл ДДЭБ-ээс хүлээн авсан дээж тус бүрийн шинжилгээний үр дүнг ADAMS-д оруулна”, Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартын **5.1.2.8-д** “Үр дүнгийн удирдлагын эрх бүх байгууллага нь энэ зүйлийн 5.1.2 зүйлд заасны дагуу тамирчны өгсөн аливаа мэдээллийг тухайн тамирчныг харьяалах үндэсний допингийн эсрэг байгууллага (олон улсын холбоо), ДДЭА-т нэгэн зэрэг өгч, допингийн эсрэг захиргаа удирдлагын систем /ADAMS/-д цаг тухайд нь мэдээлж байх үүрэгтэй”, Допингийн эсрэг үндэсний дүрмийн **14.17.4-т** зааснаар “олон улсын стандартын шаардлагын дагуу гаргасан үр дүнгийн удирдлагын ажиллагааны шийдвэрийг Олон улсын допингийн эсрэг захиргаа, удирдлагын систем (ADAMS)-ээр дамжуулан Дэлхийн допингийн эсрэг агентлагт хүргүүлнэ” гэж тус тус зохицуулжээ.

Сөрөг аналитик илэрц (AAF) болон үр дүнгийн удирдлагатай холбоотой мэдээллийг ADAMS системээр дамжуулан хуваалцах нь Дэлхийн допингийн эсрэг кодын 14 дүгээр зүйл болон Үр дүнгийн удирдлагын олон улсын стандарт (ISRM)-д тусгагдсан ил тод байдал, мэдээлэл солилцох тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд тухайн мэдээллийг ADAMS системд бүртгээгүй нөхцөл байдал нь мэдээллийн төвлөрсөн харагдах байдал болон хяналтын тогтолцооны бүрэн бүтэн, найдвартай байдалд эргэлзээ үүсгэж байна.

Дээрх зохицуулалтуудаас үзвэл дээж цуглуулах байгууллага нь ADAMS-ийг ашиглах, дээж цуглуулсан допингийн хяналтын хуудсыг 21 хоногийн дотор системд бүртгэх, ADAMS-ийн шаардлага нийцсэн дугаарлалттай өгөгдлийн кодтой байх, сөрөг аналитик илэрц нь “Шинжилгээ, мөрдөн шалгалтын” олон улсын стандартын илэрхий гажилттай холбоогүй болохыг бүртгэх, үр дүнгийн удирдлага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэрүүд зэрэг бүх процессыг нэг стандартаар бүртгэснээр мөрдөн шалгах, нотлох, хянах боломжийг олгодог. Харин лаборатори шинжилгээний үр дүнг цаг тухайд нь ADAMS-д мэдээлж байх үүрэгтэй байдаг.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын ажилтан С.Зүчи нь ХБНГУ-лсын Дрезденийн Спортын биохими ба Допингийн анализ Шинжлэх Ухаан, технологийн институт (цаашид “Лаборатори” гэх) рүү **2025.07.22-ны өдрийн 16 цаг 42 минутад** буюу допингийн шинжилгээний хариу гарахаас өмнө “Монголын үндэсний уламжлалт Наадмын арга хэмжээг зохион байгуулагч байгууллага (МЕО) нь WADA-ийн дүрэмд нэгдэн гарын үсэг зурагч тал биш юм. Иймээс бид лабораторийн хариуг ADAMS системээр бус, шууд емэйлээр хүлээн авч байгаа болно” гэж захиа явуулсан байдаг.

Допингийн шинжилгээний үр дүнгийн тайлан лабораториос 2025.7.22-ны орой 8 цагийн үед “имэйл”-ээр ирүүлсэн гэх талаарх тайлбарыг хариуцагчид гаргадаг.

Мөн ADAMS-ийг яагаад ашиглаагүй, шинжилгээний үр дүнгийн тайланг бүртгээгүй талаар Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас тодруулахад 2024, 2025 оны шинжилгээнүүдийг ADAMS-аар явуулаагүй, WADA зөвлөсөн гэх агуулга бүхий тайлбарыг гаргадаг, Үр дүнгийн удирдлагын багийн төлөөлөл сургалтаар тэгж хэлсэн, Ариунзаяа имэйл үзүүлж байсан гэх зэрэг тайлбаруудыг гаргадаг боловч WADA буюу Дэлхийн допингийн эсрэг агентлаг, RADO Бүсийн допингийн эсрэг байгууллага зөвлөсөн гэх үйл баримтыг нотлосон баримтыг хэрэгт гаргаж өгөөгүй болохыг дурдаж байна.

Н.Өсөхбаярын шинжилгээний үр дүнг ADAMS-д байгаа эсэх талаар Д.Энхсанаагийн зөвшөөрлөөр, түүний эрхээр үзлэг хийж бэхжүүлсэн болно. Үзлэгээр тамирчин Н.Өсөхбаярын ADAMS дах бүртгэлийн сангийн мэдээлэл байх бөгөөд 2023, 2024 онд өгсөн шинжилгээний үр дүнгийн тайлангууд байв. Харин 2025 оны 7 дугаар сарын 12-ны өдрийн шинжилгээтэй холбоотой мэдээлэл, шинжилгээний үр дүнгийн тайлан байхгүй байсан.

Техникийн саатал, системийн алдаа зэрэг нөхцөл байдлаас бусад тохиолдолд сөрөг аналитик илэрцтэй (AAF) холбоотой мэдээллийг ADAMS системээс гадуур удаан хугацаанд зөвхөн шууд цахим шуудангаар солилцох практик нь Дэлхийн допингийн эсрэг тогтолцоонд мөрдөгддөг ил тод байдал болон мэдээллийн мөрдөн хянах боломжтой байдлын зарчимтай нийцэж байгаа эсэхэд эргэлзээ үүсгэж байна.

Н.Өсөхбаярын 2025 оны шинжилгээний үр дүнг ADAMS-д оруулж бүртгээгүй шалтгаан нөхцөл тодорхойгүй байсан тул түүнийг тодруулах зорилгоор Бүрэлдэхүүн 2026.05.01-ны өдөр шинжилгээг хийсэн Лабораторид захидал (имэйл) явуулсан.

Лабораториос 2026.05.07-ны өдөр хариу ирүүлдэг. Н.Өсөхбаярын шинжилгээний хариуг ADAMS-д 2026.05.06-ны өдөр оруулсан болохыг мэдэгдсэн бөгөөд Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын өнгөрсөн долоо хоногт мэдээлэл ирүүлсэн бөгөөд WADA-тай зөвшилцсөний дагуу Үндэсний их баяр наадам зохион байгуулах хорооноос Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ рүү шилжүүлсэн байна. Ингэснээр бид сорьц болон шинжилгээний хариуг ADAMS системд бүртгэж, тайлагнах боломж бүрдсэн” гэж тайлбарласан.

Харин WADA-тай хэрхэн, яаж зөвшилцсөн болон яагаад шинжилгээний үр дүнг ADAMS-д тухайн үед нь бүртгээгүй талаарх шалтгааны тайлбарыг ирүүлээгүй болохыг дурдаж байна.

Эндээс үзвэл лаборатори нь Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын хүсэлтээр Н.Өсөхбаярын шинжилгээний үр дүнг ADAMS-д хожим 10 сарын дараа нөхөж оруулснаа хүлээн зөвшөөрсөн нь анхнаасаа оруулах ёстой стандартын шаардлагыг зөрчсөн гэж үзэхээр байна. Учир нь хэрэг хэлэлцэж шийдвэрлэхээс 4 хоногийн өмнө оруулж байгаа нь ямар ч процессын ул мөргүй болгож зөвхөн шинжилгээний үр дүнг харах боломжийг олгож байгаагаар ойлгогдоно. Өөрөөр хэлбэл допингийн хяналтын шинжилгээний дүн чухал, харин шинжилгээний дүн гаргахаас өмнөх үйл явц ач холбогдолгүй гэж ойлголт төрж байна. Мөн тамирчнаас дээж авахаас шинжилгээний үр дүн гарах хүртэл хэсгийг хянах, нотлох, баримтжуулах боломжгүй болгосон нь эргэлзээ бүхий нөхцөл байдлыг давхар үүсгэж байна.

Хэрэв ADAMS-ийг ашиглаж бүртгэлжүүлсэн бол Chain of Custody ба хадгалалт, тээвэрлэлтийн зам мөр, хэн хэзээ, ямар мэдээлэл оруулсан, хаана яаж ямар орчинд хадгалагдаж, тээвэрлэгдсэн эсэх нь тогтоогдохоос гадна нь нотлох баримтын найдвартай байдал хамгаалагдах байжээ. Мөн лабораторид солигдоогүй, бохирдоогүй, гэмтээгүй, допингийн хяналтын дугаар таарсан дээжүүдийг авсан эсэхийг давхар бүртгэж, баталгаажуулах байжээ.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нь ADAMS-ийг ямар үндэслэлээр, хэний шийдвэрээр ашиглаагүй талаар нотлох баримтаа гаргаж өгөөгүй, мөн WADA-гийн зөвлөгөөгөөр гэх тайлбар нь баримтаар нотлогдохгүй байгаагаас гадна, өөрсдөө 2025.07.22-ны өдөр имэйлээр шинжилгээний хариу авах хүсэлт лаборатори руу явуулсан, өөрсдөө нөхөж ADAMS-д оруулах хүсэлтийг лабораторид гаргасан зэрэг үйл ажиллагаа нь Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандарт, Лабораторийн Олон улсын стандарт, Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартуудыг ноцтой зөрчсөн байна гэж Бүрэлдэхүүн дүгнэв.

## **5. ЛАБОРАТОРИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ТАЛААР**

### **5.1.Шинжилгээний үр дүнг ирэхээс өмнөх процесс**

Дэлхийн допингийн эсрэг агентлагийн итгэмжлэл бүхий лаборатори нь Үндэсний Их Баяр наадмын 2024, 2025 оны бөх, харваачдаас авсан шээсний дээжид допингийн шинжилгээ хийсэн болохыг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ болон Үр дүнгийн удирдлагын баг, Үндэсний бөхийн салбар хорооны төлөөлөл тайлбар, мөн хэрэгт цугларсан нотлох баримтуудаар тогтоогдож байна. Уг лабораторийг хэрхэн, яаж сонгосон талаар үйл баримт байхгүй, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас энэ талаарх баримтыг гаргаж өгөөгүй болохыг дурдаж байна.

Лабораторийн Олон улсын стандартын **3.1-т** нэр томьёоны тодорхойлолт ба тайлбар хэсэгт “Шийдвэр гаргах хязгаар нь сөрөг аналитик илэрцтэй холбоотой сорьцын босго бодисын тоо, хэмжээ, үр дүнг “Лабораторийн” Олон улсын стандартад заасны дагуу тайлагнах үйлдэл” гэж заасан байна. Тухайлбал: Лабораторийн олон улсын стандарт тодорхойлсон нэр томьёонд “Аналитик шинжилгээний процедур гэж Лабораторийн олон улсын стандарт болон холбогдох техникийн баримт бичиг, техникийн захидал, эсвэл лабораторийн удирдамжид заасны дагуу аргыг баталгаажуулах, илрүүлэх шинжлэгдэхүүнийг таних, эсвэл тоон утгыг тодорхойлох замаар допингийн хяналтын дээжид хийх зорилгод тохирсон процедурыг хэлнэ”, “Баталгаажуулах процедур гэж нэг буюу хэд хэдэн тодорхой хориглосон бодис, түүний метаболит, маркерын агууламж,

харьцаа, утгыг баталгаажуулах, эсвэл гарал үүслийг (экзоген эсвэл эндоген) тогтоох зорилготой аналитик шинжилгээний процедурыг хэлнэ”, мөн стандартын 5.3.6.2-т “Баталгаажуулах процедурыг хэрэглэх гэдэгт баталгаажуулах процедурын зорилго нь сөрөг аналитик илэрц, эсвэл гаж илэрцийг тайлагнахыг дэмжих, эсвэл дэмжихгүй байх үр дүн гаргахад оршино”, мөн стандартын 5.3.8.1-д “Шинжилгээ хийсэн лаборатори нь үр дүнг хариуцаж, шинжилгээний тайланг гаргах үүрэгтэй” гэж заасны дагуу анхны шинжилгээ авсан процедурын дараа олдворыг заавал баталгаажуулах шинжилгээг хийж байж тайлагнах болохыг стандартаар заажээ.

Лабораторийн шинжилгээний үр дүн гаргахаас өмнө Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын ажилтан С.Зүчи нь лабораторийн ажилтан Sebastian Rzeppa гэх хүнтэй 2025.07.19-7.22-ны хооронд имэйлээр харилцсан байдаг. Үүнд:

- Sebastian Rzeppa-аас 2025.07.22-ны 13:25-д С.Зүчид ирүүлсэн захианд “A8373854 дугаартай дээж...харилцан тохиролцсоны дагуу энэхүү үр дүнг баталгаажуулах шинжилгээ хийгээгүй болно... A8373884 дугаартай дээж... харамсалтай нь илэрсэн үзүүлэлтүүд яг энэ агууламжийн хязгаарт байна ... иймээс энэ сорьцын тухайд цаашид хэрхэн ажиллах талаар саналыг авбал талархах болно. Бид энд сорьцуудыг ердийн допингийн сорьцуудтай адил замаар, өөрөөр хэлбэл Кёлын рүү IRMS шинжилгээ хийлгэх үү” гэжээ.

- С.Зүчи 2025.07.22-ны 12:37-д Sebastian Rzeppa-д IRMS шинжилгээний зардал хэд болох талаар асуужээ

- Sebastian Rzeppa-аас 2025.07.22-ны 15:01-д С.Зүчид 1500 евро болно, 2025.07.22-ны 22:12-д С.Зүчид IRMS шинжилгээний хариу 3-4 долоо хоног болох тухай мэдээллсэн байна.

- С.Зүчи 2025.07.22-ны 16:42-д Sebastian Rzeppa-д “...Хэрэв IRMS шинжилгээ хийхгүй бол Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага эсхүл танай Лабораторийн хувьд дүрэм журмын (compliance) хэрэгжилтийн ямар нэгэн эрсдэл үүсэх үү” гэж асуужээ.

С.Зүчийн мэдүүлснээр лаборатори имэйлээр 2025.07.22-ны оройн 20.00 цагийн орчимд допингийн шинжилгээний хариу ирсэн гэдэг ч яг хэзээ ирсэн эсэх талаарх нотлох баримт, имэйлийг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас гаргаж өгөөгүй болохыг дурдаж байна.

Дээрх захидлаас “Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага” НҮТББ нь лабораторитой урьдчилан харилцан тохиролцсоны дагуу Н.Өсөхбаярын А8373854 дугаартай дээжийн үр дүнг баталгаажуулах шинжилгээг хийхгүй”-гээр 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн оройн 20:00 цагт шинжилгээний үр дүнг хүлээн авч Үр дүнгийн удирдлагын багт хүргүүлсэн нь тогтоогдож байна.

Мөн А8373884 дугаартай дээжид байгаа агууламжийг илүү өндөр гарна гэж найдсан, цаашид хэрхэн талаар санал асуусан, IRMS шинжилгээ хийлгэх үү, IRMS шинжилгээний хариу 3-4 долоо хоног болохыг мэдээлж санал, чиглэл өгөхийг хүссэн байна. Тодруулбал IRMS шинжилгээ гэдэг хүний биед байгалиасаа үүссэн тестостерон эсхүл гаднаас орсон хэрэглэсэн синтетик тестостерон гэдгийг тогтоох шинжилгээ юм.

Энэ нь лабораторийн Олон улсын стандартад заасан “Шинжилгээний үр дүнг мэдээлэхээс өмнө давтан, эсвэл баталгаажуулах шинжилгээ хийх, дээжийг нэмэлт аналитик аргаар шинжлэх, эсвэл "А" эсвэл "Б" сорьцод өөр төрлийн нэмэлт шинжилгээ хийх зэрэг лабораторийн эрхэнд ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүй”, Допингийн эсрэг үндэсний

дүрмийн 3.3.6-д “Дэлхийн допингийн эсрэг агентлагаас магадлан итгэмжлэгдсэн, баталсан бусад лабораториуд “Лабораторийн олон улсын стандарт”-ын дагуу шинжилгээ болон хяналтын журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна. Тамирчин лабораториос гарсан таамаглалыг олон улсын стандартуудад заасан үндэслэлийн дагуу няцааж болно”, 6.6-д “Энэ дүрмийн 2.4.1-д заасан дүрэм зөрчсөн гэдгийг үндэслэж буй дээжийн тухай Үндэсний допингийн эсрэг байгууллага **тамирчинд мэдэгдэхээс өмнө** тухайн дээжийг дахин шинжлэх, эсхүл нэмэлт шинжилгээ хийх лабораторийн бүрэн эрхийг хязгаарлахгүй” гэж тус тус заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл лаборатори А сорьцод баталгаажуулах шинжилгээг хийх, түүний дараа шинжилгээний үр дүнг мэдээлэх үүрэгтэй байхад Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас асууж, үйл ажиллагаагаа хараат байдлаар явуулсан, баталгаажуулаагүй шинжилгээний үр дүнг гаргуулсан байна.

Хэрэгт авагдсан лабораторийн харилцаа холбооны баримтуудаас үзэхэд тухайн сорьцын хувьд TD IRMS техникийн баримт бичигт заасан нэмэлт хий-хроматографи/шаталт/изотопын харьцааны масс спектрометрийн (GC/C/IRMS) шинжилгээг заавал хийх нөхцөл үүссэн талаар дурдсан байх бөгөөд уг нэмэлт шинжилгээ бүрэн хийгдсэн эсэх, мөн түүний үндсэн дээр эцсийн аналитик үнэлгээг хэрхэн гаргасан талаар хэрэгт хангалттай тодорхой баримт авагдаагүй байна.

Мөн Допингийн эсрэг үндэсний дүрэмд шинжилгээний үр дүнг дүгнэх гэдгийг “Шинжилгээний үр дүнг үнэлэх тухай олон улсын стандартын 5 дугаар хэсэгт заасан үйл явцын хоорондын цаг хугацааг, эсхүл зарим онцгой тохиолдолд (жишээ нь: хэвийн бус шинжилгээний үр дүн, тамирчны биологийн паспорт мэдээллийг буруу үзүүлэх зэрэг) нэхэмжлэл гаргахаас эхлүүлж анхан шатны, эсхүл давж заалдах (давж заалдсан тохиолдолд) шатны шийдвэр гарах хүртэлх буюу Шинжилгээний үр дүнг үнэлэх тухай олон улсын стандартын 5 дугаар хэсэгт шууд заасан урьдчилсан мэдүүлгийн үе шатуудыг тус тус хэлнэ” гэж заажээ.

Эдгээрийг нэгтгэж дүгнэвэл Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ болон Лаборатори хоорондоо А8373854 дугаартай дээжийн шинжилгээний үр дүнгийн талаар урьдчилан харилцан тохиролцсон, харилцан тохиролцсон (хийхгүй байхаар) ёсоор олдворыг баталгаажуулах шинжилгээг хийгээгүй, А8373884 дугаартай дээжид IRMS шинжилгээг хийхгүйгээр (3-4 долоон хоног болно, төлбөр нь 1500 евро болно гэж мэдээлсэн) шинжилгээний үр дүнг тайлагнуулсан болох нь тогтоогдож байна.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ болон Лаборатори нь Лабораторийн Олон улсын стандартын дээрх заалтуудыг зөрчсөн, үйл ажиллагаагаа Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас хараат байдлаар явуулсан, шинжилгээний үр дүнгийн талаар урьдчилан харилцан тохиролцсон, заавал хийх баталгаажуулах шинжилгээг хийгээгүй, шинжлэх ухааны үндэслэлтэй тайланг гаргаагүй зэрэг олон ноцтой зөрчлийг гаргасан байхаас гадна процедурын хувьд эргэлзээ төрүүлхүйц нөхцөл байдлыг бүрдүүлж байна гэж Бүрэлдэхүүн дүгнэв.

## **5.2.Шинжилгээний үр дүнгийн тайлан ирсэний дараах процесс**

Лабораторийн ажилтан Sebastian Rzeppa-аас 2025.07.23-ны 15:50-д С.Зүчид ирүүлсэн захианд:

1. IRMS шинжилгээг заавал хийнэ. IRMS шинжилгээг хийхгүйгээр хариуг хэзээ ч гаргадаггүй.
2. WADA лабораторийн шаардлагыг дагаж мөрдөхийн тулд IRMS шинжилгээг хийхгүйгээр тайланг гаргах боломжгүй.
3. Нэмэлт товч тайлбар: "... лабораторийн хувьд IRMS шинжилгээ хийхгүйгээр ийм төрлийн сорьцын эерэг эсхүл сөрөг гэж үнэлэх нь WADA-ийн дүрэм журамд нийцэхгүй бөгөөд мэргэжлийн ёс зүйн хувьд ч боломжгүй зүйл. Хэрэв IRMS шинжилгээний дүн сөрөг гарсан тохиолдолд тамирчин магадлалтай "хуурамч эерэг" үр дүнгээр шийтгүүлэх бус, харин өөрийн сорьцыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлүүлэх нь тамирчны эрх ашигт мөн адил нийцэх ёстой. Иймээс цаашид IRMS шинжилгээний нэмэлт зардлыг санхүүгийн төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй болов уу. Өмнөх Наадмын сорьцуудад аз болоход IRMS шинжилгээ хийхгүйгээр зохицуулж болсон ч ийм төрлийн шинжилгээнээс үргэлж зайлсхийх боломжгүй гэдгийг бодит байдал харуулж байна..." бичжээ.

Энэхүү захидлаас IRMS-ийг "заавал" хийх шинжилгээ бөгөөд үүнийг хийхгүйгээр эерэг/сөрөг гэж үнэлэх тайланг гаргах боломжгүй, энэ нь WADA-ийн дүрэмд нийцэхгүй, IRMS хийгээгүй бол "худлаа сөрөг"(false positive) үүсэх эрсдэлтэй, энэ нь тамирчныг буруу шийтгэгдэхээс хамгаалах ёстой болохыг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагад анхааруулсан байна.

Ингэж мэдэгдэж анхааруулсаар байтал Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага нь 1500 евро төлж уг шинжилгээг хийхгүйгээр өмнөх өдөр (2025.07.22) нь допингийн шинжилгээний үр дүнгийн тайланг Үр дүнгийн удирдлагын багт өгч, улмаар 2025.07.23-ны өдөр допингийн эсрэг дүрмийн мэдэгдлийг боловсруулсан ноцтой зөрчлийг гаргасан байна. Үүнийг лабораторийн захианаас үзвэл лабораторийн эцсийн, албан ёсны тайлан гэж үзэхээргүй байна.

Мөн анхаарал татахуйц ноцтой нэг зүйл нь Лабораториос "Өмнөх Наадмын сорьцуудад аз болоход IRMS шинжилгээ хийхгүйгээр зохицуулж болсон ч ийм төрлийн шинжилгээнээс үргэлж зайлсхийх боломжгүй гэдгийг бодит байдал харуулж байна" гэж бичсэн байдаг.

Учир нь 2024 оны Үндэсний их баяр наадмын шинжилгээний дээжид уг лаборатори шинжилгээ хийсэн бөгөөд "Аз болоход", "Зохицуулж болсон ч" гэж бичсэн нь стандартын бус эсхүл урьдчилан харилцан тохиролцож шинжлэх процессыг явуулсан байж болзошгүй байна. Мөн "IRMS шинжилгээ хийхгүйгээр" ямар шинжилгээний үр дүнгийн тайлангуудыг гаргасан эсэх нь мөн онцгой анхаарал татаж байна. Энэ нь лабораторийн үйл ажиллагаа, шинжилгээний үр дүн, тайлангууд нь стандартын дагуу явагдаж гарсан эсэхэд бүхэлд нь онцгой эргэлзээ төрүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. (Мөн 2024 оны шинжилгээний үр дүнг ADAMS-д оруулаагүй байдаг)

Н.Өсөхбаярын мэдээллийг ADAMS системд хугацаанд нь бүртгээгүй, Лаборатори болон Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ хооронд урьдчилсан тохиролцоо хийгдсэн, лабораторийн ажиллагааны хараат бус байдал, тайлагналын хэлхээний бүрэн бүтэн байдал, улмаар шинжилгээний үр дүнгийн нотлох чадвар, найдвартай байдалд үндэслэл бүхий эргэлзээ үүсэж байгаа нь процедурын зөрчлүүдийг тус

тусад нь бус харин харилцан уялдаа бүхий “системийн шинжтэй зөрчил” байна гэж Бүрэлдэхүүн дүгнэв.

## **6. В сорьцоо нээлгэх тамирчны үндсэн эрхийг хязгаарласан эсэх**

Өргөдөл гаргагч Н.Өсөхбаяр 2026.01.09-нд гаргасан өргөдөлд “... Үндэсний бөхийн салбар хорооны үр дүнгийн удирдлагын баг надтай хамтран ажиллах гэрээ байгуулж намайг хорлосон этгээдүүдийг олж тогтоож эрхийг минь сэргээн, оногдуулж болох шийтгэлийг багасна гэж найдлага төрүүлж В дээж нээлгэх эрхээс татгалзуулсан атлаа намайг хорлосон байж болзошгүй этгээдийн талаар мөрдөн шалгалт хийгээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулалгүй миний барилдах эрхийг 4 жилээр хассан нь анхнаасаа намайг хорлох санаа зорилго хэн нэгэнд байсан энэ санаа зорилгоо бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн байж магадгүй гэж би хардаж байгаа учраас танай байгууллагад өргөдөл гаргаж” гэсэн байдаг.

Энэ тохиолдолд Н.Өсөхбаярын мэдүүлсэн бодис болох Only for Russia team-ийн талаар урьдчилан Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ мэдэж байсан эсэх, уг бодист мөрдөн шалгалт явуулж байсан эсэх, хамтран ажилласан, бодит туслалцаа үзүүлсэн гэх үйл баримтуудад цогцоор үнэлэлт, дүгнэлт өгч байж В сорьцын татгалзлын талаар дүгнэлтийг өгөхөөр байна гэж Бүрэлдэхүүн үзэв.

### **6.1. Мөрдөн шалгалтын ажиллагааны талаар**

С.Зүчи нь гэрчээр мэдүүлэг өгөхдөө “Only for Russia team гэх нэртэй бодисыг 2024 оны 3 дугаар сард анх мэдсэн, 4 төрөлтэй, тухайн үед 1 төрөлтэй гэж бодож байсан, мөрдөн шалгалтын ажиллагаа явагдаж байсан” гэх, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ийн Ерөнхийлөгч Ц.Уугангэрэлийн 2025.12.22-ны Нийслэлийн прокурорын газарт явуулсан “2025 оны 04 дүгээр сар Only for Russia team гэх бэлдмэлийн мөрөөр орж мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа” гэсэн албан бичиг, Д.Энхсанаа гэрчээр мэдүүлэхдээ “Ер нь бол тодорхой хэмжээний мэдээлэл бол байсан... ер нь бол сэжиглэсэн, яагаад гэвэл Only for russian team гэсэн тэр бодист нөгөө ийм боломжтой байх учраас. Яагаад гэвэл бид нарт урьдчилсан тийм нөгөө сэжиг байсан” гэх мэдүүлгүүдийг өгсөн.

Мөн Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ийн Ерөнхийлөгч Ц.Уугангэрэл нь Ц.Хосбаяраас худалдан авсан гэх Only for Russia team гэсэн бодисыг 2025 оны 4 болон 10 дугаар саруудад ХБНГУЛсад шинжилгээнд хамруулахад хориотой бодисын жагсаалтад хамааралгүй “Рибоксин” эм байсан бөгөөд зүрхний булчингийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай гэж прокурорт гаргасан тайлбараас үзвэл уг бодисыг наадмаас өмнө буюу 2025 оны 4 сард шинжлүүлж байсан байна.

Эдгээр мэдүүлгүүд болон нотлох баримтуудыг нэгтгэн дүгнэвэл Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нь Only for Russia team гэх бодисын талаар анх 2024 оны 3 дугаар сараас эхлэн мэдэж байсан, шинжлүүлж байсан, мөрдөн шалгалтын явуулж байсан гэх нөхцөл байдал тогтоогдож байна.

С.Зүчи нь Дэлхийн допингийн эсрэг агентлагийн Мэдээлэл цуглуулах нэгжийн менежер Марк Ватерстэй 2025.06.12-6.13-ны өдрийн хооронд имэйлээр харилцсан захианд Марк Ватерс нь “цагдаад хураагдсан 2025 оны багц бодисоос нэмж дээж авах хүсэлтэй байгаа, цагдаад байгаа бодис нь хэдэн төрлийн байсан гэж бид анзаарсан” гэж, С.Зүчи “хураагдсан эд зүйл цагдаад байгаа, дасгалжуулагчийн мэдээлэл өгсөн хүнтэй холбогдсон, бэлтгэлийн төлөвлөгөөний хуулбар, тун хэмжээ, хэрэглэх өдрүүдийг өөрийн гараар тэмдэглэсэн байсан, аудио бичлэг олсон” гэжээ.

Марк Ватерс нь С.Зүчи рүү 2025.06.16-ны өдөр “Манай Шинжлэх ухааны баг Монголын хууль сахиулах байгууллагад 2025 оны “Russia substance” гэх бодисоос нэг ампулийг авч, Германд шинжлүүлэх хүсэлттэй байгаа бичиг хийж байна” гэж имэйлээр бичсэн. Энэхүү захидлаас харвал “Russia substance” гэх нэршил бүхий бодисыг авч Германд шилжүүлэх хүсэлтийг гаргасан байна.

С.Зүчиэс Марк Ватерс рүү 2025.07.22-ны өдрийн 16:43 минутад явуулсан захианд “WADA ийн Гарын үсэг зурагч бус-Монголын Үндэсний Их баяр наадмын үеэр авсан тэмцээний үеийн допингийн хяналтын шинжилгээтэй холбоотой дараах шинэ нөхцөл байдлыг бий болгосон талаар мэдээлэх гэсэн юм. Тамирчны Допингийн хяналтын хуудас (DCF)-д “Russia substance” гэж мэдүүлсэн байна. Гэвч лабораторийн шинжилгээгээр тийм бодис илрээгүй. Харин сорьцоос Drostanolone болон Clomiphene илэрсэн. Үүгээр дасгалжуулагч Хосбаяр нь тухайн мэдүүлсэн “Russia substance”-ийг худалдсан гэдгийг нотолхуйц баттай, бодит баримтууд болоод байна. Цаашид ямар арга хэмжээ авах талаар зөвлөгөө өгнө үү” гэжээ.

Уг захидалтай бусад нотлох баримт, үйл явдлыг харьцуулвал үзвэл:

- a. С.Зүчи хариу ирэнгүүт (оройн 20.00 цагт) нь Only for Russia team бодисын талаар WADA-д мэдэгдсэн гэж мэдүүлсэн. Уг захианд хариу гарахаас 4 цагийн өмнө мэдээлсэн нь өөрийнхөн өгсөн мэдүүлэгээсээ зөрж байна.
- b. Н.Өсөхбаярийн шинжилгээгээр мэдүүлсэн бодис нь илэрээгүй өөр төрлийн бодисууд илэрсэн байна.
- c. Өөр хоёр төрлийн бодисоор дасгалжуулагч Хосбаяр нь тухайн мэдүүлсэн “Russia substance”-ийг худалдсан гэдгийг нотолхуйц баттай, бодит баримтууд болсон гэжээ.

Дүгнэвэл Н.Өсөхбаярын лабораторийн шинжилгээний үр дүн гараагүй, тайлагнаагүй байсан. Тодруулбал: Н.Өсөхбаярын 7.23-ны өдөр мэдэж, 7.25-ны өдөр хамтран ажиллахаа илэрхийлсэн, 7.28-ны өдрийн орчим Хосбаярыг гэж зааж, мэдээлэл өгч, баримт, үлдэгдэл бодисоо гаргасан өгсөн байдаг. Дээрх захиаг явуулснаас хойш 6 хоногийн дараа буюу 7.28-ны өдөр Хосбаярыг зааж худалдан авснаа хэлж, бодисоо өгсөн байхад С.Зүчи нь “Хосбаяр нь тухайн мэдүүлсэн “Russia substance”-ийг худалдсан гэдгийг нотлохуйц баттай, бодит баримтуудтай болсон” нь ойлгомжгүй байна.

Тодруулбал Хосбаяр нь Н.Өсөхбаярт худалдсан болохыг, Н.Өсөхбаяр нь Хосбаяраас худалдан авсан гэх үйл явдлыг илэрхийлэх хамтын ажиллагааг явагдаж эхлээгүй байхад, ямар нотлохуйц үндэслэл бүхий баттай, бодит баримтуудыг хэрхэн, яаж, хаанаас олж авсан нь эсэх нь тогтоогдохгүй байна.

С.Зүчиэс 2025.08.12-ны өдөр Дэлхийн допингийн эсрэг агентлагын Мэдээлэл цуглуулах нэгжийн дарга Даммез Ларинд илгээсэн захианд “... Only for Russia Team дээжийн тухайд, цагдаагийн байгууллагын мэдэлд үйлдвэрлэсэн огноо нь өөр 3 төрлийн ампул хадгалагдаж байгаа. Мөн үндсэн бодис болох “Russia command” эсхүл “Russia team” гэж нэрлэгддэг бодисыг олж авахад маш ойрхон байна. Уг бодис ойролцоогоор 30 хоногын илэрүүлэх хугацаатай гэж мэдээлэгдсэн бөгөөд дараа нь Only for Russia Team ампул хэрэглэснээр нөлөөг нь дахин идэвжүүлж болдог гэж байна... Шинээр гарч ирсэн, гол гэрчтэй болсон, гэрчээс дэлгэрэнгүй мэдүүлэг, чат, дуут мессеж, санхүүгийн баримт, холбогдох бодисыг өгсөн” талаар дурджээ.

Уг захидлаас дүгнэвэл “Russia substance”, “Russia command”, “Russia team”, “Only for Russia Team” гэх нэршил бүхий олон төрлийн бодисуудад мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан бөгөөд “Only for Russia Team” нь үндсэн бодис биш байхаар байна.

С.Зүчи 2026.04.23-ны өдөр мэдүүлэхдээ Н.Өсөхбаяр хамтран ажиллах хүрээнд гарган өгсөн дэлгэрэнгүй мэдүүлэг, чат, дуут мессеж, санхүүгийн баримт, холбогдох бодисын мэдээлэл, баримтыг WADA-гийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа баримтуудыг энэ хэрэгт гарган өгөхгүй боломжгүй гэж хэлдэг. Харин уг мэдүүлэг өгөхөөс өмнө буюу 2026.04.20-ны уг хамтын ажиллагаанд хүрээнд WADA-гийн тусгай шагнал хүртсэн болохоо нийтэд мэдээлсэн байдаг.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас Н.Өсөхбаярын хэрэгт бичгээр ирүүлсэн тайлбарт "... хамтран хэрэгжсэн бөгөөд ийм төрлийн хамтын ажиллагааны ач холбогдлыг Дэлхийн допингийн эсрэг агентлаг үнэлж, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нь энэ чиглэлээр тусгай шагнал хүртсэн" гэснээс үзвэл Н.Өсөхбаяртай хамтран мөрдөн шалгалт явуулсны дүнд уг шагналыг хүртсэн болохоо илэрхийлсэн байна.

Тамирчин Н.Өсөхбаярын сорьцоос Drostanol (AAF), Clorphine-ний ул мөр илэрсэн бөгөөд Clorphine-ий ул мөрийг давтан шинжлэх шаардлагатай талаар захидалд дурдсан боловч ҮДУ-ын мэдэгдэлд зөвхөн Drostanol илэрсэн хэмээн мэдэгдсэн байна. Тухайн Clorphine ул мөрний илэрцтэй холбоотой нэмэлт тодруулга, шинжилгээ хийсэн тохиолдолд тамирчин хориотой бодисыг санаатайгаар хэрэглэсэн эсэх, эсхүл бохирдол, санамсаргүй хэрэглээтэй холбоотой эсэхийг үнэлэхэд ач холбогдолтой байж болох байсныг баталгаажуулаагүй байдаг.

Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **12.3.2**-т "Допингийн эсрэг байгууллага нь мөрдөн шалгалтын үр дүнд үндэслэн шийдвэр гаргаж, тамирчин, эсвэл тамирчныг дэмжигч этгээдийн эсрэг хэрэг үүсгэж байгаа бол тухайн шийдвэрийн талаар "Үр дүнгийн удирдлагын" олон улсын стандартад заасны дагуу мэдэгдэх ба дүрмийн 8 дугаар бүлэгт заасны дагуу хэргийг хянан шийдвэрлэнэ", **12.3.3**-т "Допингийн эсрэг байгууллага нь мөрдөн шалгалтын үр дүнд үндэслэн тамирчин, эсвэл тамирчныг дэмжигч этгээдийн эсрэг хэрэг үүсгэхгүй байх шийдвэр гаргасан бол" заасны дагуу шалгалтын үр дүнд Ц.Хосбаярт хэрэг үүсгэсэн эсхүл үүсгээгүй шийдвэрийг гаргасан байхыг шаардах бөгөөд энэ талаарх баримтыг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ гаргаж өгөөгүй болохыг дурдаж байна.

Допингийн эсрэг үндэсний дүрмийн **10.23**-т "Тамирчин ба бусад этгээд Үндэсний допингийн эсрэг байгууллага, цагдаагийн болон мэргэжлийн бусад байгууллагад бодит туслалцаа үзүүлснээр дор дурдсан үр дүн гарсан тохиолдолд Үндэсний допингийн эсрэг байгууллага энэ дүрмийн 13 дугаар хэсэгт заасны дагуу давж заалдах шийдвэр гарахаас өмнө, эсхүл давж заалдах гомдол гаргах хугацаа дуусахаас өмнө тухайн хэрэгт ногдуулсан шийтгэлийг (эрх хасагдсан хугацаа эхлэх, олон нийтэд мэдээлэхээс өмнө) түр түдгэлзүүлж болно, **10.23.1**.Үндэсний допингийн эсрэг байгууллага өөр этгээдийн үйлдсэн дүрмийн зөрчлийг илрүүлсэн" гэж заасны дагуу Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага нь Хосбаярын мэдээллийг авч ирүүлсэн бол Н.Өсөхбаярын шийтгэлийг түдгэлзүүлэх шийдвэрийг гаргах боломжтой байсан ч энэхүү шийдвэрийг гаргасан эсэх нь тодорхойгүй байна.

## **6.2. Хамтран ажилласан эсэх талаар**

### **6.2.1. Only for Russia team бодисын талаар 2025.07.12-ны өдөр мэдсэн эсэхэд**

Н.Өсөхбаяр нь 2025.7.12-ны өдрийн Допингийн хяналтын хуудас (DCF)-д сүүлийн 7 хоног хэрэглэсэн гэх Only for Russia team бодисыг хэрэглэсэн гэдгээ Д.Энхсанаад хэлж бичүүлсэн байдаг.

Д.Энхсанаа нь “2025.7.12-ны өдөр уг бодисын талаар Допингийн хяналтын хуудсыг бөглөж байхдаа тодорхой хэмжээний мэдээлэлтэй байсан, сэжиглэсэн, судалж байсан бодис мөн байна гэж бодож байсан ... бүх шинжилгээнүүдийг бүгдийг нь нөгөө лац дуугаар бүх юмаар нь дахиад тулгаад тэгээд тэр нөгөө цүнхийг нь лацдаад хөлдөөгч рүү хийдэг...тэгэхдээ тэр бүх хуудаснуудыг бүгдийг нь 2 салгаад лаборатори руу явахыг нь тусад нь, нөгөө эх хувийг нь тусад нь салгаж байгаад тэгээд тэр бүгд дуусангуут нь тэр хуудсаа Ерөнхий нарийн бичгийн даргад өгнө. Тэгэхээр нь нөгөө Ерөнхий нарийн бичиг албан бичиг бичээд тэр хуудсыг нөгөө дугтуйнд хийгээд наагаад өгөнгүүт албан бичиг бичээд цуг наадмын зохион байгуулах хороо руу явуулна” гэж мэдүүлдэг.

Гэрчийн мэдүүлгээс харвал Н.Өсөхбаярыг “Only for Russia Team” гэх бодис хэрэглэсэн гэж мэдүүлсэн болохыг 2025.7.12-ны Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын холбогдох удирдлага, ажилтнууд мэдээгүй гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Тодруулбал Допингийн хяналтын хуудас (DCF), Хадгалалт, тээвэрлэлтийн хуудас (Chain of Custody form) нь хоёр хувь үйлдэгдэж нэгийг С.Зүчид, нэгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан байхаар байна. Энэ нь тухайн үед ADAMS-д бүртгүүлж оруулаагүй байх тул эх хоёр хувь нэг байгууллагын хяналтад цаасан хэлбэрээр байсан байна. Эдгээр хоёр баримт нь допингийн шинжилгээний дээж цуглуулах, тээвэрлэлт болон шийтгэл оноох эсхүл оноохгүй байх үндсэн баримт юм.

Эдгээр хоёр баримтууд хаана, хэрхэн хадгалагдсан эсэх, засвар өөрчлөлт ороогүй эсэх нь нотлогдохгүй байгаагаас гадна тухай үйл явцыг баримтжуулсан бичгэн болон видео хэлбэрийн бичлэг, бусад холбогдох нотлогдохуйц баримтуудыг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас шаардсан боловч гаргаж өгөөгүй болохыг Бүрэлдэхүүн дурдаж байна.

### **6.2.2. Хамтран ажиллах болон бусад хэлбэрийн гэрээ, хэлцэл хийгдсэн эсэх**

А. Н.Өсөхбаяр нь 2026.01.23-ын өдөр гаргасан өргөдөлдөө “Үндэсний бөхийн салбар хорооны үр дүнгийн удирдлагын баг надтай хамтран ажиллах гэрээ байгуулж... найдлага төрүүлж В дээж нээлгэх эрхээс татгалзуулсан атлаа ...” гэж дурдсан.

Үндэсний бөхийн салбар хорооны дарга Н.Мягмараас 2025.07.29-ны өдрийн 01/37 дугаар албан бичгээр Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай байгаа Only for Russia Team гэх бодисын лавлагааг гаргуулахаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулах газарт хандсан бичиг явуулсан байна.

Мөн Үр дүнгийн удирдлагын багийн 2025.08.06-ны өдрийн хуралдаанд тэмдэглэлд Гишүүн Д.Давааням “... Та үр дүнгийн удирдлагын багтай тохиролцсон гэрээ, хэлцлээ зөрчсөн. Цаашид энэ үйлдлээ ямар нэгэн байдлаар үргэжлүүлэх юм бол гэрээний үүргээ биелүүлээгүй гэдэг үндэслэлээр таны шинжилгээний хариу, шинжилгээ авахад мэдүүлсэн Допингийн хяналтын хуудас дээрх хэрэглэсэн бодисууд, нотлох баримт, лабораторийн эх хувьтай нь олон нийтэд мэдээллэхээс өөр аргагүй нөхцөл байдал үүснэ.Үүнийг танд албан

ёсоор мэдэгдэж байна”, мөн “бид хамтын ажиллагааны гэрээг нилээн хамгаалж ярьлаа шүү” гэж тэмдэглэл үйлдсэн байна.

Дээрх гэрчийн мэдүүлэг болон бусад баримтаас дүгнэвэл Үр дүнгийн удирдлагын баг Н.Өсөхбаяртай хамтран ажиллах агуулга бүхий гэрээг байгуулсан байна.

Үр дүнгийн удирдлагын багаас Н.Өсөхбаяртай байгуулсан гэрээг хэрэгт гаргаж өгөөгүй болохыг дурдаж байна.

Хамтран ажиллах гэрээг гаргаж өгөөгүй тул хэрэгт цугларсан бүхий л баримтуудыг харьцуулан үзвэл тамирчин В сорьцыг нээх эрхээсээ татгалзах, хамтран ажиллах (бодис зарсан хүнээ зааж өгөх, холбогдох баримт, гүйлгээний мэдээлэл болон бодисоо гарган өгөх), Үр дүнгийн удирдлагын баг хорлосон байж болзошгүй этгээдийн талаар мөрдөн шалгалт явуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, барилдах эрхийг 4 жилээс бууруулах эсхүл багасгах байдлаар хамтын ажиллагааны тохиролцоо хийгдсэн байх боломжтой байна гэж үзлээ.

**Б.** Үр дүнгийн удирдлагын багийн 2025.07.25-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд С.Зүчиэс “хамтран ажилласан тохиолдолд шийтгэлийг хөнгөлж болох, хуулийн болон бусад зөвлөгөө туслалцаа үзүүлдэг, хүнээ зааж бидэнтэй хамтрах талаар санал” гаргасан байдаг.

С.Зүчийн мэдүүлгээр “Н.Өсөхбаяртай 2025.07.28-ний өдөр уулзаж Only for Russia team манай сонихорлын бодисыг чи мэдүүлсэн байна, бид өөрсдөө хамтран ажиллах санал тавьсан, хамтран ажиллана гэдгээ тохирсон” гэдэг болон Н.Өсөхбаяр үндсэн хуралдаанд нь “хамтран ажиллавал гэм буруугүй болно гэх ойлголтыг төрүүлсэн тэгээд бэлдсэн нэг хувь гэрээнд гарын үсэг зуруулж авсан, надад хувь өгөөгүй” гэх тайлбаруудыг гаргадаг.

Дээрх үйл баримтууд болон С.Зүчийн WADA-д явуулсан захидлууд зэргээс нэгтгэж үзвэл Н.Өсөхбаяртай Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **12.2.4**-т заасан “Тамирчин болон тамирчныг дэмжигч этгээд нь дүрмийн 21 дүгээр бүлэгт заасны дагуу допингийн эсрэг байгууллагын явуулж буй мөрдөн шалгалттай хамтран ажиллана” гэсний дагуу мөрдөн шалгалт явуулж байсан ажиллагаанд бодит туслалцаа үзүүлэх агуулга бүхий байдлаар хамтран ажилласан байна гэж үзлээ.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага болон С.Зүчи нь Н.Өсөхбаяраар гарын үсэг зуруулж авсан гэх гэрээг хэрэгт гаргаж өгөөгүй бөгөөд өөрийн өгсөн гэрчийн мэдүүлэгтээ аман гэрээ хийсэн гэж мэдүүлэг өгсөн болохыг дурдаж байна. Энэ нь Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **11.3.1**-д “Допингийн эсрэг байгууллагууд нь допингийн эсрэг бүх мэдээллийн хүлээн авсан нөхцөл байдал, найдвартай болон үнэн зөв байдал, эх үүсвэрийн шинж чанар, тухайн мэдээллийг олж авах эсвэл хүлээн авах шалтгааныг үнэлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Тамирчин Н.Өсөхбаяртай байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу В сорьцоо нээх эрхээс нь татгалзуулсан, бодис зарсан хүнээ зааж өгөх, холбогдох баримт, гүйлгээний мэдээлэл болон бодисоо гарган өгсөн байна. Харин тамирчнаас Үр дүнгийн удирдлагын баг болон Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ нь байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу амлалтдаа хүрээгүй, мөн анхнаасаа намайг хорлох санаа зорилго хэн нэгэнд байсан

энэ санаа зорилгоо бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн байж магадгүй гэж би хардаж байна гэх тайлбарыг үгүйсгэх үндэслэл тогтоогдохгүй байна гэж Бүрэлдэхүүн дүгнэв.

## **В. Тамирчны хэрэглэсэн гэх бодисыг гаргаж өгсөн тухай**

Хамтран ажиллах тохироогоор С.Зүчи нь “Н.Өсөхбаяр бодистой холбоотой үлдэгдэл, тухайн бодисыг Only for Russia, 2 ампул бүтэн, үйлдвэрийн лацтай, баримт мэдээлэл, нотлох баримтуудыг, чат, баримтын гүйлгээг гаргаж өгсөн... 2 ампул өгсөн, нэгийг нь цагдаад өгсөн нөгөөг нь 9 сар хавьцаа бид нар WADA-руу явуулсан” гэх мэдүүлэг, Үр дүнгийн удирдлагын багийн 2025.08.06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд С.Зүчи “...Н.Өсөхбаярын нотлох баримтаар гаргаж өгсөн тариаг шинжлүүлэхээр лабораторид өгсөн” гэх баримтууд хэрэгт авагджээ. Тодруулбал С.Зүчи нь Н.Өсөхбаярын хэрэглэсэн гэх бодисоос 2 ампулыг болон баримт мэдээлэл, нотлох баримтуудыг, чат, баримтын гүйлгээг авсан болох нь тогтоогдож байна.

Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын **11.1.3** болон 12 дугаар зүйлийн 12.2 Болзошгүй допингийн эсрэг дүрмийн зөрчлийг мөрдөн шалгах хэсгийн **12.2.2-т** “Допингийн эсрэг байгууллага нь болзошгүй зөрчилтэй холбоотой хүлээн авч болохуйц, найдвартай нотолгоог гаргаж ирэхийн тулд аль болох хурдан хугацаанд холбогдох мэдээллийг цуглуулах, тэмдэглэл хийх, эсвэл энэ төрлийн нотолгоог бий болгох цаашдын чиг баримжааг тодорхойлно. Допингийн эсрэг байгууллага нь ямар ч үед шалгалт шударга, бодитойгоор явагдаж байгаа эсэхийг баталгаажуулна. Шалгалтын явц, мэдээллийн боловсруулалт болон тухайн шалгалтын хүрээнд гаргаж ирсэн нотолгоо, шалгалтын үр дүнг бүрэн баримтжуулна” гэж зохицуулжээ.

Дээрх стандартаар мөрдөн шалгалтын ажиллагаа явагдаж байсан бодисыг тамирчнаас авахдаа тэмдэглэл хийх замаар бодисын нэр, хаяг, шошго, төрөл, хэлбэр, тоо ширхгийг найдвартай нотлох, уг процесс нь бодиттой, шударга явагдсан эсэхийг баталгаажуулах, нотолгоог бүрэн баримтжуулахыг заажээ.

С.Зүчи нь стандартыг зөрчиж ямар ч тэмдэглэл, баримтжуулалтыг хийгээгүйгээс болж 2 ампулыг яг хэзээ авсан, тухайн бодис нь ямар нэр, төрөл, хаяг, шошготой, хуурай эсхүл шингэн байсан эсэх, “Russia substance”, “Russia command”, “Russia team”, “Only for Russia Team” гэх бодисын аль нь байсан эсэхийг тогтоох боломжгүйгээр тамирчнаас авсан байна. Улмаар тамирчны хэрэглэсэн бодис мөн эсэх, Хосбаяраас авсан гэх бодис мөн эсэх, Хосбаяраас хураагдаж шинжилгээнд орсон “Рибоксин” эм байсан эсэхийг тогтоох боломжгүйгээр мөрдөн шалгах ажиллагааг явуулж, тамирчны эрхийг ноцтой зөрчсөн байна гэж Бүрэлдэхүүн дүгнэв.

Г. Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын Ерөнхийлөгч Ц.Уугангэрэлийн бичигт Н.Өсөхбаярын дээжээс гарсан бодис өөрийн гаргаж өгсөн бодистой таарсан гэх, Н.Өсөхбаярын шинжилгээнээс гарсан бодис, гаргаж өгсөн бодисуудын найрлаг таарсан уу гэхэд надад байгаа мэдээллээр таарсан гэж С.Зүчи мэдүүлдэг. Мөн Эрүүгийн цагдаагийн газарт гаргаж өгсөн гэх нэг ампул бодист Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ өөрөө шинжээчийн үүрэг гүйцэтгэсэн гэдэг.

Харин Н.Өсөхбаярын дээжээс гарсан бодис, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-д гаргаж өгсөн гэх бодистой таарсан талаарх шинжлэх ухааны

үндэслэлтэйгээр шинжилсэн лаборатортийн баталгаажсан дүгнэлт, холбогдох баримтыг ирүүлээгүй бөгөөд энэ талаар нотлох баримтыг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-аас хэрэгт гаргаж өгөөгүй болохыг дурдаж байна.

Шинжилгээ, мөрдөн шалгалтын стандартын **11.2.2-т** заасан “Допингийн эсрэг байгууллага нь допингийн эсрэг мэдээллийг хүлээж авах, хүлээн авахыг зөвшөөрсөн, мэдээллийн эх сурвалжийн нууцлал болон аюулгүй байдлыг хамгаалсан, мэдээлэл алдагдах болон задруулах эрсдэлийг зохих ёсоор шийдсэн өөрийн бодлого, журамтай байх шаардлагатай. Боловсруулсан мэдээллээ хууль сахиулах байгууллага болон бусад эрх мэдэл бүхий хуулийн этгээд болон гуравдагч талтай хуваалцана”, Допингийн эсрэг үндэсний дүрмийн **14.4-т** “Энэ дүрмийн 14.1-д заасныг дагаж мөрдөх зорилгоор зөрчилтэй холбоотой мөрдөн шалгалт үргэлжилж байгаагаас бусад тохиолдолд Үндэсний допингийн эсрэг байгууллага нь энэ дүрмийн 14.2-т заасныг удирдлага болгон энэ дүрмийн 7, 8, 13 дугаар хэсэгт зааснаар явагдсан аливаа хяналтын ажиллагааны хүрээнд тухайн этгээдийн талаар, допингийн эсрэг бусад байгууллагуудын байр суурь, шинэ илэрцийн тухай мэдээлэл, шийдвэрийн шалтгааны талаар үндэслэл бүхий тайлбарыг бичгээр үйлдэн хүргүүлнэ” гэсний дагуу Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ боловсруулсан мэдээллээ хуваалцаагүй, шалтгааны талаар үндэслэл бүхий тайлбарыг бичгээр ирүүлээгүй тул “таарсан” гэх үйл баримт нь шударга, үнэн зөв явагдаж үр дүнд хүрсэний эсэх нь нотлогдохгүй байна Бүрэлдэхүүн үзлээ.

Тамирчинтай хийсэн харилцаа нь албан ёсны процессын гадуур явагдсан бол энэ нь шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжтой нөхцөл байдал үүсгэсэн байна. Процедурын эрхийн ноцтой зөрчил нь шинжлэх ухааны нотолгооны хүчийг дангаараа хүчингүй болгох хэмжээний эрх зүйн нөлөөтэй гэдгийг онцолж байна.

Н.Өсөхбаяр шинжилгээний хариуг гурван удаа хүлээн зөвшөөрч В сорьцоо нээхгүй, хамтран ажиллаж байгаа, би хорлогдчихлоо хуулийн байгууллагын асуудлыг шийдэх хүртэл хүлээгээч гэх агуулга бүхий өргөдлүүдийг гаргасан байдаг. Энэхүү гурван удаагийн өргөдлийн суурь нөхцөл нь Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ болон Үр дүнгийн удирдлагын багтай тохиолцсон тохиролцоо байх боломжтой бөгөөд тамирчин А хүлээн зөвшөөрч, В өгөхгүй байх, хамтран ажиллах, түүний үр дүнд шийтгэлийг бууруулах, багасгах эсхүл гэм буруугүй болно гэх ойлголтыг тамирчинд төрүүлсэнтэй холбоотой байна.

В сорьцын нээх, нээхгүйтэй холбоотойгоор тамирчин бүрэн мэдээлэлтэй байж, сайн дурын үндсэн дээр аливаа хөндлөнгийн нөлөөллөөс ангид байдлаар эрхээ эдлэх ёстой. Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ болон Үр дүнгийн удирдлагын баг “хамтран ажиллавал шийтгэл буурна эсхүл гэм буруугүй болно” гэсэн хууль ёсны хүлээлт үүсгэх ойлголтыг Н.Өсөхбаярт өгсөн байх боломжтой байна. Учир нь Н.Өсөхбаяр нь хуралдаанд гаргасан тайлбартаа “допингийн холбоо бол за манайх шалгаж болно оо, гэрээгээ байгуулчих, чи очоод цагдаагийн байгууллагадаа очоод тийшээгээ өргөдөл өгчих, манайхаас хэрэг хянан шийдвэрлэлт хийчихнэ, үнэн зөвийг нь тогтоочихно” гэж хэлсэн гэжээ.

Үр дүнгийн удирдлагын багтай гэрээ байгуулсан, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын ажилтан С.Зүчи нь нэг хувь гэрээнд гарын үсэг зуруулан авч

үлдсэн, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ мөрдөн шалгах ажиллагааг явуулж байсан боловч уг ажиллагаа нь В сорьцоо нээлгэх эрхийг эдлэхээс тусдаа харилцаа бөгөөд В сорьцыг аливаа нөлөөллөөс ангид, бүрэн мэдээлэлтэйгээр бие даан шийдвэрлэх эрхэд нөлөөлөх ёсгүй юм.

В сорьц нь тамирчин өөрийгөө шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхээ хамгаалах үндсэн эрх бөгөөд хэрэв В сорьцын үр дүн А-г батлахгүй бол үр дүн, шийтгэл нь өөр болох, харин В сорьцын үр дүн А-г баталбал эхний шинжилгээний үр дүн батлагдах үйл явц юм. Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 2.1.2-т “Тамирчны “В” сорьц шинжлэгдэж, “В” сорьцын дүн нь А сорьцод хориглосон бодис, түүний маркер, метаболит илэрсэн болохыг дахин баталсан” гэж заасны дагуу В сорьц шинжлэгдээгүй байх тул А сорьц дахин батлагдаагүй байгааг дурдах нь зүйтэй.

Иймээс тамирчны татгалзлыг “албан ёсны, мэдээлэлтэй шийдвэр биш” болгох “хамтарвал шийтгэл буурна эсхүл гэм буруугүй” гэсэн ойлголт өгсөн албан бус яриа эрх зүйн үр дагаврыг буруу ойлгуулсан байна гэж үзэхээр байна.

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ мөрдөн шалгаж байсан бодисыг олж авах зорилгыг нэн түрүүнд тавьж хамтран ажиллахыг санал болгосон, Үр дүнгийн удирдлагын багтай хамтран ажиллах гэрээг байгуулсан бөгөөд эдгээрийн хариуд нь тамирчны шийтгэлийг багасгах эсхүл гэм буруугүй болгоно гэх ойлголтыг төрүүлэн В сорьц нээлгэх эрхийг төөрөгдүүлэх замаар хязгаарласан байна гэж Бүрэлдэхүүн дүгнэлээ.

## **7. Хараат бус байх зарчим алдагдсан тухай**

Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ-ын ажилтан С.Зүчи нь дараах ажил, үүргийг гүйцэтгэсэн байна.

- 1) Итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Билгүүний хуралдаанд өгсөн тайлбараар Мөрдөн шалгах комиссын дарга,
- 2) Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын Ерөнхийлөгчийн 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 50 дугаар тушаалаар Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч,
- 3) ашиг сонирхлын мэдүүлэг бөглөхдөө Гадаад харилцааны дарга,
- 4) Chain of Custody form дээр дээж тээвэрлэгч,
- 5) Үндэсний бөхийн салбар хорооны шийдвэрээр Үр дүнгийн удирдлагын багийн гишүүн
- 6) Н.Өсөхбаяртай хамтран ажилласан
- 7) Лабораторитой харилцаж байсан

гэх олон давхар чиг үүргийг нэг хүн гүйцэтгэж болох нь тогтоогдсон. Энэ нь Допингийн эсрэг дүрэм, стандартуудыг Үр дүнгийн удирдлагын бие даасан, хараат бус байдал, Лабораторийн бие даасан, хараат бус байдал, Шинжилгээний объектив байдал, процессын шударга байдлын талаар ноцтой эргэлзээг улам нэмэгдүүлж байна.

Тухайлбал Лаборатори нь Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага НҮТББ, Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч, Мөрдөн шалгах ажиллагаанаас тусдаа байж

хараат бусаар ажиллах үндсэн зарчимтай. Шинжилгээний тайлан эцэслэн гарахаас өмнө лабораторитой идэвхтэй, тогтмол харилцаж байсан нь урьдчилан харилцан тохиролцсон, төвийг сахих зарчим алдагдсан, нууцлалын үйл явц алдагдсан, лабораторид нөлөөлөх оролдлого хийсэн гэх ноцтой эргэлзээ үүсгэж байна.

С.Зүчи нь сорьц авах ажиллагаа, Chain of Custody, лабораторитой үр дүн гарахаас өмнөх харилцаа, мөрдөн шалгах ажиллагаа, үр дүнгийн удирдлага болон шийдвэр гаргах түвшний ажиллагаанд давхар оролцсон нь Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Үр дүнгийн удирдлага Олон улсын стандарт болон Шинжилгээ, мөрдөн шалгалтын Олон улсын стандартын болон Допингийн эсрэг үндэсний дүрэмд заасан Хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй, шударга ажиллагааны үндсэн зарчмыг ноцтойгоор зөрчсөн нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Ийнхүү нэг этгээдийн төвлөрсөн оролцоо нь процессын шударга байдал, лабораторийн үр дүнгийн объектив байдал болон үр дүнгийн ажиллагааны шударга байдалд үндэслэл бүхий эргэлзээ үүсгэж байна гэж Бүрэлдэхүүн дүгнэлээ.

Эцэст нь энэхүү шийдвэр нь допингийн бодис илэрсэн эсэхийг үгүйсгээгүй бөгөөд зөвхөн процессын шударга байдал хангагдаагүй нөхцөлд нотлох баримтын эрх зүйн хүчин чадал хангалтгүй гэж үзсэн болно. Шударга бус процессоор хүрсэн үнэн нь эрх зүйн хувьд үнэн гэж тооцогдохгүй. Нотлох баримтыг үгүйсгэх биш, харин тэр баримтыг бий болгосон процесс нь эргэлзээтэй байна. Допингийн бодисын илрүүлэлтийн аналитик дүгнэлт нь өөр бусад шинжлэх ухааны нотолгоогоор шууд няцаагдаагүй байна. Иймд Бүрэлдэхүүн лабораторийн үр дүнг өөрөө дангаараа хүчин төгөлдөр нотлох баримт байж болох зарчмыг үгүйсгээгүй болно. Гэвч Дэлхийн допингийн эсрэг дүрмийн дагуу зөвхөн шинжилгээний техникийн үнэн зөв байдал хангалттай биш бөгөөд тухайн шинжилгээний үр дүнд хүргэсэн процессын бүрэн бүтэн байдал, тасралтгүй байдал, хараат бус байдал зэрэг нь нэгэн адил эрх зүйн хувьд заавал хангагдсан байх шаардлагатай. Эрх зүйн үр дагаварт хүргэх шийдвэр гаргахын өмнө нотлох баримт нь процессын хувьд найдвартай, шалгагдах боломжтой, мөн хараат бус байдлын хувьд эргэлзээгүй байхыг шаарддаг. Үүний улмаас Бүрэлдэхүүн нь шинжилгээний үр дүнг шинжлэх ухааны хувьд няцаагаагүй боловч уг үр дүнд хүргэсэн процессын эрх зүйн найдвартай байдал хангалтгүй гэж дүгнэв.

Мөн энэхүү шийдвэр нь холбогдох хуулиуд болон Дэлхийн допингийн эсрэг дүрэм, түүнд нийцүүлэн гаргасан Олон улсын стандартууд болон Допингийн эсрэг үндэсний дүрмийг нэгдмэл байдлаар хэрэглэх цаашдын практикт ач холбогдолтой гэж Бүрэлдэхүүн дүгнэв. Учир нь зөвхөн Допингийн эсрэг дүрмийн нэгээс олон хэд хэдэн заалтыг зөрчсөн үйлдэл нь хангалттай үндэслэлээр нотлогдож байгаагаас гадна үйл ажиллагааны шат бүрд дүрмийн зөрчил гарсан, бүхэлд нь авч үзвэл системийн болон институтийн хараат бус байдал, стандартын үйл ажиллагаа нь ноцтой зөрчигдсэн, ноцтой зөрчлүүдээс болж зөвхөн өргөдөл гаргагчаар хязгаарлагдахгүй нийт тамирчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх цаашлаад зөрчигдөх үр дагавар үүсгэх өндөр эрсэлтэй байгаа тул мэргэжлийн байгууллагын мэргэжлийн бус үйл ажиллагааг зөвтгөх боломжгүй юм.

"Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага" НҮТББ 2025 оны 07 дугаар сарын 12-ны өдөр Монгол үндэсний бөхийн тамирчин Н.Өсөхбаяраас допингийн шинжилгээнд зориулж дээж цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулахдаа "Шинжилгээ,

мөрдөн шалгалтын" олон улсын стандартаас илт гажсан болохыг тогтоолгох шаардлагыг хангаж шийдвэрлэв. Харин хорлогдсон гэх асуудал нь хуулийн байгууллагаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байх тул энэ талаар дүгнэлт өгөх боломжгүй гэж Бүрэлдэхүүн үзэв. Нэгэнт тамирчны эхний шаардлагыг хангаж шийдсэн тул Дэлхийн допингийн эсрэг дүрэм, түүнд нийцүүлэн гарсан Олон улсын стандартууд, Допингийн эсрэг үндэсний дүрмийн хүрээнд цаашид үр дагавар үүсэхгүй тул өргөдлийн 2, 3, 4 шаардлагыг хангах үндэстэй байна гэж Бүрэлдэхүүн үзэв.